МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,163.319... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.09.13. Лхагва. №155 (4769) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +24
Шөнө +9

**ҮЗЭЛ БОДОЛ**

Ж.ЭРДЭНЭБАТЫН ЗАСГИЙН ГАЗАР БА ҮР ДАГАВАР

III нүүрт

**ОНЦЛОХ ХУУДАС**

ИРГЭД ЗАСГИЙН ГАЗРЫГ ШУДАРГА ХҮМҮҮСЭЭР БҮРДҮҮЛЭХИЙГ ХҮСЛЭЭ

V нүүрт

Дугаарын 60 мөр

## Шинэ ургацын ногоо идмээр байна

Н.БОЛД

Жил бүрийн наймдугаар сарын эхээр шинэ ургацын ногоо түрүүчээсээ гарч ирдэг. Зарим нь бүр долдугаар сарын сүүлчээр шинэ ургацын ногоо Улаанбаатар хотын гудамжинд гаргаж тавьдаг. Үнэн ч юм уу, худлаа ч юм уу. За тэгээд есдүгээр сарын дунд үеэс эхлээд нийслэлд нутаг нутгийн шинэ ургацын ногооны үзэсгэлэн худалдаа гардаг байлаа. Гэтэл энэ жил юун үзэсгэлэн худалдаа манатай. Сураг ч алга. Зах, худалдааны төвүүдээр мэр сэр шинэ ургацын ногоо үзэгдэж байна билээ. Мөн энд тэнд шинэ ургацын ногоо зарж байгаа сүүдрэвчнүүд байгаа. Гэхдээ өмнөх жилүүдийг бодвол шинэ ургацын ногооны сураг ч алга гээд хэлчихэд сүржигнэсэн болохгүй байх.

Үргэлжлэл нь III нүүрт

# ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХЭРЭГЛЭГЧИЙН БОЛОВСРОЛ




Үргэлжлэл нь III нүүрт







**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2444.00 | 2460.00 | ФУНТ | 3183.00 | 3263.00 |
| ЕВРО | 2894.00 | 2958.00 | РУБЛЬ | 41.80 | 43.90 |
| ИЕН | 22.20 | 22.70 | ЮАНЬ | 372.80 | 377.50 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2445.00 | 2462.00 | ФУНТ | 3187.00 | 3274.00 |
| ЕВРО | 2902.00 | 2971.00 | РУБЛЬ | 42.00 | 44.46 |
| ИЕН | 22.10 | 22.76 | ЮАНЬ | 374.00 | 377.90 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

Би монголоо ингэж хөгжүүлнэ

# Ч.Хашчулуун: Нүүрсний зах зээл цаашид нэг их тэлэхгүй



Г.ГАНЧИМЭГ

*Монголчууд бүгдээрээ хошуу дүрж мэдэлддэг нэг салбар бий болсон нь уул уурхай. Ялангуяа сүүлийн үед дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ өсчээ гэдгийг ёстой ам уралдуулан ярьж, яг одоо очоод мөнгө авах гэж байгаа юм шиг зарим нь авирлав. Харин эдийн засагч хүн хөндлөнгийн байр суурьнаас харж, ондоо өнцөг гаргах юм. МУИС-ийн Эдийн засгийн их сургуулийн багш, доктор Ч.Хашчулуунтай нүүрсний зах зээлийн төлөв байдал, хандлагын талаар ярилцлаа.*

**-Дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ өсчээ. Энэ нь манай эдийн засагт яаж нөлөөлөх бол?**

-Нүүрсний дэлхийн зах зээл гэж байдаггүй. Хүмүүс дандаа андуурдаг. Хольж хутгаад "Нүүрсний зах зээл тэглээ, ингэлээ" гэж ярьдаг. Гэтэл нүүрс нь дотроо хоёр зах зээлээс бүрддэг. Эхнийх нь эрчим хүчний буюу бидний ярьдагаар хүрэн нүүрс. Энэ нь тусдаа өөр зах зээл. Бараа нь бол ижилхэн нүүрс мөн л дөө. Хэрэглээний хувьд эрэлт, нийлүүлэлт нь шал өөр байдаг юм. Энэхүү хүрэн нүүрс нь дэлхийд маш элбэг. Хятад, Америк, Энэтхэг, Индонез, Австрали гэсэн таван орон л нийт зах зээлийн 70 хувийг эзэлдэг. Ер нь хамгийн том үйлдвэрлэгч нь хамгийн том хэрэглэгч байдаг сонин зах зээл. Харин нөгөөдөх нь төмөрлөгийн үйлдвэрт ган хайлуулахад хэрэглэдэг коксжих нүүрс юм. Коксжих нүүрстэй ойролцоо нь занар байдаг учраас зарим үед орлуулдаг. Гэхдээ нүүрс дэлхийд элбэг барааны нэг л дээ. Манай улсад нүүрс олборлоод 100 гаруй жил болж байна. Гэхдээ дотоодын хэрэглээ нь бага. Сүүлийн үед л нүүрсний хэрэглээ өсөх хандлагатай байна. Гол хэрэглэгч нь гадаадын зах зээлд байдаг. Өмнөд хөрш БНХАУ манай гадаад хэрэглээний гол том зах зээл нь шүү дээ. Яах вэ, бусад оронд бага зэргээр гаргаж байсан түүх бий. Манай улсын нүүрсний хамгийн том үйлдвэрлэгч "Эрдэнэс Тавантолгой" , дараа нь МАК, тэгээд "Саусгоби сэндс", "Энержи ресурс" буюу жижиг Тавантолгой гэх мэтээр эрэмбэлэгдэнэ. Эндээс харахад, экспортын нүүрсийг ихэвчлэн "Эрдэнэс Тавантолгой", МАК хоёр гаргадаг нь тодорхой байна.

**-Манайхан чинь сүүлийн 10 жилийн турш "Монголын баялгийг харийнхан зөөгөөд дууслаа.**

**Үргэлжлэл нь VI нүүрт**

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Х.Энхжаргал: 49 хоногийн хугацаанд нэг ч хүн оффшор бүсээс мөнгөө татаагүй

Ерөнхийлөгч Х.Баттулга оффшор бүсэд данстай улстөрчид, төрийн албан хаагчид, тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүдэд хандан долдугаар сарын 24-ний өдрөөс хойш 49 хоногийн дотор оффшор дансаа хааж, тэнд байршуулсан мөнгөн хөрөнгөө Монголын банкинд оруулж ирэхийг уриалсан билээ. Түүнээс хойш өчигдөр 49 хоногийн хугацаа өнгөрч, өчигдрөөр дуусгавар болов. Ерөнхийлөгчөөс уриалсан хугацаа дууссантай холбогдуулан уг уриалгын биелэлт, ажлын явц байдалтай танилцахаар ЕТГ-ын дарга З.Энхболд өчигдөр АТГ-ын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргалыг хүлээн авч уулзлаа. З.Энхболд дарга "Монгол Улсын Эрүүгийн хууль, Татварын хууль, бусад хуулиар аливаа компанийн хөрөнгө, мөнгө бүртгэлтэй, татвар төлөгдсөн байх ёстой. Энэ бүгд ил байх ёстой. Ерөнхийлөгчийн гаргасан уриалгын 49 хоногийн хугацаа өчигдөр дууссан" гээд энэ хугацаанд ямар ажил хийж, ямар үр дүнд хүрээд байгаа талаар тодруулахыг хүсч буйгаа хэлэв. Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргалын хэлснээр өнгөрсөн хугацаанд нэр бүхий 23 хүнийг гурав гурван удаа дуудан уулзсан бөгөөд өнөөдрийн байдлаар Монгол Улсад сайн дураар оруулж ирсэн хөрөнгө мөнгө байхгүй гэлээ. Ажлын явц байдлын талаар Ерөнхийлөгчид нууцын зэрэглэлтэй мэдээлэл өгснөө мөн танилцууллаа.

## Үндсэн хуулийг өөрчлөх асуудлаар 239600 санал иржээ

УИХ-ын Тамгын газраас Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд иргэдээс ирүүлсэн саналыг нэгтгэн цахим архивт хэрхэн бүртгүүлж байгаа талаар мэдээлэл өглөө. УИХ-ын гишүүн, Ажлын хэсгийн гишүүн Г.Занданшатар энэ үеэр хийсэн мэдээлэлдээ, "УИХ-ын Байнгын хороодоор ахлуулсан долоон баг 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт нийт 63 удаагийн хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулж, энэ ажилд 4705 төрийн албан хаагч, 12797 иргэн оролцсон дүнтэй байна. Мөн бүх сум, баг, хороод, төрийн болон төрийн бус байгууллагуудын хүрээнд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулагдлаа. Нийт 239 600 санал ирснээс 129 258 санал аймгуудаас, 110 000 саналын хуудас нийслэлд ирээд байна. УИХ-ын Тамгын газрын Мэдээлэл, технологийн хэлтэс иргэдийн бүх саналыг цахим хэлбэрт оруулах тусгай программ бүтээж, Тамгын газрын ажилтнууд Төрийн тусгай албаны давхар хяналтад байдаг камераар тоноглогдсон танхимд иргэн бүрийн саналыг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн зүйл, заалт бүрээр нь цахим хэлбэрт оруулж байна. Хуулийн төсөлд тусгагдаагүй саналуудыг ч мөн бүртгэж, цахим хэлбэрт оруулж байна. Иргэдийн саналыг цахим хэлбэрт оруулсны дараагаар архивын нэгж үүсгэж мэдээллийн сан бүрдүүлнэ. Ингэснээр иргэн бүр өөрийн саналыг улсын архивын нэгдсэн сангаас үзэх боломж бүрдэнэ" гэлээ.

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн Б.ӨНӨРТОГТОХ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ШАР МЭДЭЭ



## Ерөнхий сайдын марафонд хэн түрүүлэх вэ

Б.ЭРХЭС

Ж.Эрдэнэбатын тэргүүлсэн Мэргэжлийн Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцроод зургаа хоног өнгөрөөд байна. Энэ хугацаанд яамдын сайд нар үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байгаа бол Ерөнхий сайд асан Ж.Эрдэнэбатын ажлыг Шадар сайд У.Хүрэлсүх орлож байгаа юм. Дараагийн Засгийн газар хэрхэн бүрдэх, сайдууд хэн болох, тэр дундаа Гүйцэтгэх засаглалыг удирдах тэргүүн нь хэн байх вэ гэсэн марафон МАН дотор хэдийнэ өрнөж, дор бүрнээ л сайд болох санаархлаа илэрхийлж эхлээд байгаа. Өвөл хаянд ирчихсэн, ургац хураалт, хадлан тэжээл гэх мэт ид ажлын үеэр засаг төр үймсэнд ард түмэн бухимдаж эхэлсэн. Тиймдээ ч дараагийн Засгийн газрыг МАН цаг алдалгүй байгуулах шаардлагатай байгаа юм. Энэ бүхнийг цэгцлэхээр МАН-ын бүлэг шуурхайлж эхэлсэн гэх мэдээлэл байна. Тодруулбал, өнөөдөр МАН-ын бүлэг хуралдаж Засгийн газрын бүтэц, намын Бага хурлын товыг хэлэлцэх бол Удирдах зөвлөлийн хурал баасан гарагт товлогдсон гэдгийг эх сурвалж онцоллоо. МАН-ын бүлэг Төрийн ордонд хуралдах бол Удирдах зөвлөл хэдэн цагт хаана хуралдах талаар мэдээлэл өгөөгүй байгаа аж. Мөн өнөөдөртөө багтаж Удирдах зөвлөл хуралдана гэсэн яриа ч гараад амжлаа. Бүлгийн хуралдаанаас өмнө МАН-ын фракциуд нууц уулзалт хийж эхэлсэн тухай яриа саарал ордонд хэдийнэ тархжээ. Тухайлбал, М.Энхболдын тэргүүлдэг хотын фракци Сэлх зусланд сэмхэн уулзсан бол У.Хүрэлсүхийн тэргүүлдэг залуусын фракци ч дараагийн Ерөнхий сайдын тохироог өнгөрөгч амралтын өдрүүдэд ярьсан сурагтай. Одоогоор Ерөнхий сайдын марафонд У.Хүрэлсүх, Ц.Нямдорж, Ж.Энхбаяр, С.Бямбацогт, Н.Энхболд нарын нэрс яригдаж байгаа юм. Харин тулаанд хэн илүүрхэхийг Бага хурал шийдэх биз ээ.

## ТББ-ууд Сүхбаатарын талбайд жагсана гэв

О.УЯНГА

Гадаадын аль нэг улсад оффшор данстай улстөрчдийг 49 хоногт багтаан мөнгөө эх орон руугаа татахыг Монгол Улсын Ерөнхийлөгч уриалсан. Энэ хугацаа өчигдөр дууссан юм. Гэвч, нэг ч хүн оффшор бүсээс мөнгөө татаагүй, мөн 60 тэрбумын бичлэгтэй холбоотой асуудлаар хууль хяналтын байгууллага дорвитой ажил хийхгүй байгаа тул ТББ-ууд нэгдэн хэвлэлийн бага хурал зарлаж, тэмцэхээ илэрхийллээ.

Хэвлэлийн бага хуралд Ард түмний онц түр зөвлөл, Монголын нам бус иргэдийн нэгдсэн холбоо, Хохирогчдын холбооны төлөөлөл оролцсон бөгөөд энэ үеэр Сүхбаатарын талбайд энэ сарын 23-ны 12:00 цагт жагсаал хийхээр болсноо мэдэгдэв. Мөн ард иргэдийг тус жагсаалд идэвхтэй оролцохыг уриалсан юм. Ард түмний онц зөвлөлийн гүйцэтгэх захирал Ц.Нарангэрэл "Ерөнхийлөгч Х.Баттулга Оффшор бүсэд данс эзэмшдэг улстөрчдийг мөнгөө татаж, өөрийн орны банкны дансанд байршуулахыг өнгөрсөн долдугаар сарын 24-ний өдөр уриалсан байдаг. Өнөөдрийн байдлаар 49 хоногийн хугацаанд оффшор бүсээс мөнгөө татаж байршуулсан мэдээлэл тодорхойгүй байна. Мөн 60 тэрбумын асуудал шийдэгдэхгүй МАНАН дунд замхрах гэж байгаа тул ард түмэн хүчтэй гэдгийг харуулах цаг нь болсон. 60 тэрбумын бичлэг эвлүүлэг биш гэдгийг УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж, намын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалан нар ч хэлсэн" гэв.

Хууль зааснаар, оффшор бүсэд данс нээлгэсэн, мөнгө хөрөнгө байршуулсан, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд байгуулсан этгээд гурван сарын дотор дансаа хаалгах, мөнгөн хөрөнгөө татах, өмчийн эрхээ худалдах, шилжүүлэх, татах, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, захиран зарцуулах эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох арга хэмжээ авч өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаар 30 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт шинэчлэн мэдүүлэх үүрэгтэй юм байна.

## АН-ынхан Өмнийн говьд чуулав



Ардчилсан нам шнэчлэлийн бодлогынхоо хүрээнд жил бүр бүсчилсэн чуулгануудаа хийхээр болсон. Энэ жилийн хувьд дөрвөн аймаг, нийслэлийн хоёр дүүргийг хамруулсан Зүүн бүсийн чуулганаа өнгөрсөн наймдугаар сард Хэнтий аймгийн Биндэр суманд хийсэн бол отгон чуулганаа Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутаг "Жуулчин говь" жуулчны баазад хийлээ. Бүсийн чуулганаар Үндсэн хуулийн өөрчлөлтийн асуудал, Ардчилсан намын Үзэл баримтлалын төслийг хэлэлцэж, УИХ-ын Хаврын чуулганы мэдээлэл, УИХ дахь АН-ын бүлгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл сонсч, намын үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлж байгаатай танилцуулав. Түүнчлэн УИХ-ын гишүүд, намын удирдлагуудын илтгэлийг сонсч, улс төр, нийгэмд өрнөж буй үйл явдлын талаар шинэ соргог бодитой мэдээлэл авсандаа орон нутгийн намын гишүүд олзуурхаж байсан юм. Энэ өдрүүдэд мөн төрийн болон намын шагнал авсан гишүүддээ Ардчилсан намын удирдлагууд хүндэтгэл үзүүлж, шагналыг нь гардуулж өгөхийн зэрэгцээ урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулж, шилдгүүдээ шалгаруулж шагнаж урамшуулсан юм. Бүсийн чуулганд ирсэн гишүүд Ардчилсан нам шинэчлэгдсэнээр жирийн гишүүдийнхээ оролцоог дээшлүүлж аливаа асуудалд бүх гишүүдийнхээ саналыг авдаг болсныг онцолж, бүсийн чуулгануудаар дамжуулан улс төрийн идэвхийг сэргээж, мэдлэгийг нь дээшлүүлж байгаад талархалтай хандаж байв. Түүнчлэн нам нэгдсэн нэг цул хүчин болсноор 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулж, улс орны хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулж, эрх баригчдын алдааг засч, сайныг нь дэмжих хүчтэй сөрөг хүчин бүрдүүлж байгаад намын удирдлагууддаа талархал илэрхийллээ. Ийнхүү дөрөв хоногийн турш Өмнийн говьд чуулсан ардчилагчид шинэ соёл, шинэчлэлийн ажлаа үргэлжлүүлэхээр нутаг буцацгаав.

МОНГОЛ ДЭЛХИЙН ХЭВЛЭЛД

# Ж.ЭРДЭНЭБАТЫН ЗАСГИЙН ГАЗАР БА ҮР ДАГАВАР




Б.ДАВААХҮҮ

БНХАУ, ОХУ гэсэн хоёр томоохон гүрний дунд орших гуравхан сая хүн амтай, байгалийн баялагаараа дэлхийд наймдугаарт эрэмбэлэгддэг далайд гарцгүй Монгол Улсын эдийн засгийн болоод улс төрийн асуудал аль хэдийнэ олон улсын анхаарлыг татах болсон билээ. Монголын жүдогийн тамирчдын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд гаргасан амжилт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Владивостокийн Дорнын эдийн засгийн чуулганы үеэр хэлсэн үг, дэлхийн төрийн тэргүүнүүдтэй хийсэн уулзалт, Ж.Эрдэнэбатын Засгийн газар огцорсон гээд сүүлийн өдрүүдэд Монголын тухай сайн нь ч, саар нь ч дэлхийн хэвлэлийн хуудаснаа нийтлэгдсээр байлаа. Харин тэр бүх мэдээллээс энэ удаагийн "Монгол дэлхийн хэвлэлд" буландаа Монгол Улсын Засгийн газар огцорсон хийгээд цаашид гарах үр дагаварын талаар хоёр хөршийн болон Японы томоохон мэдээллийн агентлаг хэрхэн мэдээлснийг сонирхуулахаар бэлтгэлээ.

## NHK: Хойд Солонгосын эсрэг авах арга хэмжээнд сөргөөр нөлөөлж болзошгүй

"Мэргэжлийн" гэх тодотголтой Ж.Эрдэнэбатын Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулсан тухай олон улсын хэвлэл бүр өөр өөрийн байр сууринаас мэдээлж байгаа. Тэгвэл Японы "NHK" агентлагийн цахим хуудсанд манай улсын Засгийн газрын тогтворгүй байдлыг Хойд Солонгосын асуудалтай илүүтэй холбон мэдээлжээ.

Үүнд "Хойд Солонгостой онцгой харилцаатай Монгол Улсын парламент энэ сарын 7-нд мэргэжлийн сайдаар хангаж чадаагүй зэрэг шалтгааны улмаас Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлаар санал хураалаа. Гэвч, тус улсын энэ мэт улс төрийн эмх замбараагүй байдал нь Хойд Солонгосын эсрэг авах арга хэмжээнд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Монголд өнгөрсөн оны зургадугаар сард болсон парламентын сонгуулиар тухайн үед хамгийн том сөрөг хүчин байсан МАН 80 гаруй хувьд ялалт байгуулж, Ж.Эрдэнэбат Засгийн газрыг тэргүүлэх болсон юм. Гэтэл энэ сарын 7-нд болсон УИХ-ын ээлжит бус чуулганаар мэргэжлийн сайдаар хангаж чадаагүй гэх шалтгааны улмаас Засгийн газрыг огцруулах тухай саналыг эрх баригч намын гишүүдийн талаас илүү хувь нь дэмжсэнээр Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорсон юм. Өнгөрсөн долдугаарсард Ерөнхийлөгчийн сонгуульд сөрөг хүчний нэр дэвшигч ялалт байгуулснаас хойш эрх баригч МАН-ын дотоод дахь сөргөлдөөн улам бүр гүнзгийрэх болсон бөгөөд дараагийн Ерөнхий сайдыг сонгох хүртэл нэлээд хугацаа зарцуулах төлөв ажиглагдаж байна.

Монгол Хойд Солонгостой уламжлалт найрсаг харилцаатай төдийгүй, онцгой харилцаа холбоотой улс юм. Өмнө нь тус улсын нийслэл Улаанбаатар хотод Япон болон Хойд Солонгосын Засгийн газар хоорондын уулзалт, хэлэлцээр болж байсан удаа бий. Түүнчлэн, Засгийн газар огцрохоос нэг хоногийн өмнө Ерөнхий сайд Шинзо Абэ Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгатай анх удаа уулзсан юм.

Монголд Ерөнхийлөгч "Ард түмний эв нэгдлийн бэлгэ тэмдэг" бөгөөд эрх мэдэл нь хязгаарлагдмал байдаг. Гэвч, Засгийн газар нь огцорсонтой холбоотойгоор үүссэн өнөөгийн улс төрийн эмх замбараагүй байдал удаан үргэлжилбэл цөмийн болон баллистик пуужингийн хөгжүүлэлтээ үргэлжлүүлсээр буй Хойд Солонгосын эсрэг авах арга хэмжээнд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна" хэмээн бичжээ.

## Reuters: Монголын бондын үнэ уналаа

Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорсны дараа олон улсын зах зээл дэх Монгол Улсын бондын үнэ унаж эхэлсэн тухай "Reuters" агентлаг мэдээлсэн байв. Тэрхүү мэдээлэлд "Монголын парламент өнгөрсөн долоо хоногийн пүрэв гарагийн орой Ерөнхий сайдаа огцруулахаар шийдвэрлэсэн. Тэгвэл үүнээс нэг хоногийн дараа буюу баасан гарагт Монголын бондын үнэ унаж эхэлжээ.

"Tradeweb data"-ын мэдээлснээр, Монголын 2022 онд буцаан төлөх ёстой "Чингис" бондын ханш 0.462 центээр унаж, нэгжийн үнэ нь 97.539 цент болжээ. Энэ нь өнгөрсөн долдугаар сараас хойшхи хамгийн их унасан үзүүлэлт болж байгаа юм.

Түүнчлэн, 2021 онд төлөх ёстой бондын ханш 0.270 центээр буурснаар нэгж бондын ханш 117.729 цент болжээ.

Эрх баригч Монгол Ардын нам долдугаар сард болсон Ерөнхийлөгчийн сонгуульд ялагдал хүлээсний дараа парламентаар Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатыг огцруулсан. ОХУ, БНХАУ-ын дунд орших асар их баялагтай, хүн ам цөөнтэй тус улсад 2004 оноос хойш нэг ч Ерөнхий сайд бүрэн эрхийн дөрвөн жилийн хугацаагаа гүйцээгээгүй билээ" гэжээ.

## XINHUA: МАН–ын гишүүд өөрсдөө Засгийн газраа огцруулав

БНХАУ-ын төрийн мэдлийн "Синьхуа" агентлагийн цахим хуудаст манай улсын улс төрийн өнөөгийн нөхцөл байдлын тухай мэдээ нийтлэгдсэн байна. Тэрхүү мэдээлэлд "Монголын хууль тогтоогчид

> ...Түүний кабинетын гишүүд ч гэсэн өөрт холбогдох асуудлыг үгүйсгэсэн мэдэгдэл хийж, тэд болон тэдний гэр бүл концессын гэрээтэй ямар ч холбоогүй хэмээн мэдэгдэж байсан юм. Олон Улсын валютын сангийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй Монголын Засгийн газар унасан нь далайд гарцгүй тус улсын эдийн засаг болон улс төрд томоохон эрсдэл дагуулж болзошгүй байна...

өнгөрсөн долоо хоногийн пүрэв гарагийн шөнө Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатыг кабинетых нь гишүүд чадваргүй, дээр нь концессын гэрээ тойрсон авлигад нэр холбогдсон гэх шалтгаанаар огцруулжээ.

Түүнд итгэл үзүүлэх эсэх хуралдаанд 73 гишүүн оролцсон бөгөөд МАН-ын 31 гишүүн огцруулах шаардлагагүй гэж үзсэн бол 42 гишүүн эсрэг санал өгсний 33 нь эрх баригч намын гишүүн, найм нь сөрөг хүчин Ардчилсан намынх, үлдсэн нэг нь бие даагч гишүүн байсан юм. Ж.Эрдэнэбатын Засгийн газар 2016 оны долдугаар сард байгуулагдсанаас хойш 14 сарын дараа огцорч байна.

Эрх баригч Монгол ардын намын хэсэг гишүүд сөрөг хүчин Ардчилсан намын гишүүдтэй нэгдэн Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатыг Засгийн газрын гурван гишүүний хувийн компанитай нийт 328 сая ам.долларын концессын гэрээ байгуулж, парламентын журмыг зөрчсөн хэмээн буруутгаж байв. Харин Ж.Эрдэнэбат "Сүүлийн 25 жилд Монгол Улс 13 Засгийн газрын нүүр үзлээ. Тэдгээр Засгийн газрын ердөө хоёр нь л дөрвөн жилээ гүйцэт ажилласан байхад үлдсэн 11 нь 1-2 жил л ажилласан. Засгийн газрыг огцруулах нь хариуцлага тооцох гэхээсээ илүүтэй эдийн засаг, улс орны хөгжил дэвшлийг удаашруулах буруу жишиг тогтоож байна" гэдгийг хуралдааны үеэр тодотгож байлаа.

Түүний кабинетын гишүүд ч гэсэн өөрт холбогдох асуудлыг үгүйсгэсэн мэдэгдэл хийж, тэд болон тэдний гэр бүл концессын гэрээтэй ямар ч холбоогүй хэмээн мэдэгдэж байсан юм. Олон Улсын валютын сангийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй Монголын Засгийн газар унасан нь далайд гарцгүй тус улсын эдийн засаг болон улс төрд томоохон эрсдэл дагуулж болзошгүй байна. Олон улсын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчид Монголын улс төрийн нөхцөл байдалд санаа зовнисоор ирсэн бөгөөд Монгол Ардын намын удирдлага дор байгуулагдсан Засгийн газар тогтвортой ажиллаж чадна гэдэгт ихээхэн найдлага тавьж байсан юм. Гэсэн ч, түүхэндээ анх удаагаа парламентад 65 суудалтай эрх баригч МАН-ын гишүүд өөрсдөө Засгийн газраа огцрууллаа. "Алтан Бумба" санхүүгийн группын шинжээч Дэйл Чой "Долдугаар сард болсон Ерөнхийлөгчийн сонгуульд эрх баригч намын нэр дэвшигч ялагдсаны дараа бий болсон намын дотоод улс төрийн асуудлаар Ерөнхий сайдаа огцруулсан. Шинэ Ерөнхий сайд өмнөх Сангийн сайдыг албан тушаалд нь дахин томилж байж, хөрөнгө оруулагчдыгтайвшруулахболов уу. Гэхдээ, тэгээгүй байсан ч Олон Улсын Валютын сангийн хөтөлбөрийг үргэлжлүүлэх хангалттай олон технократ гишүүн бий" гэж ярилаа.

Монгол Улсын хуулийн дагуу УИХ-аас 45 хоногт багтаан шинэ Ерөнхий сайд болон түүний кабинетыг байгуулж, Ерөнхийлөгч батлах ёстой. Харин шинэ Ерөнхий сайд болон түүний кабинет бүрэлдэх хүртэл Ж.Эрдэнэбат болон түүний Засгийн газар үүрэгт ажлаа гүйцэтгэх билээ.

Дугаарын 60 мөр

## Шинэ ургацын ногоо идмээр байна

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Уг нь бид чинь шинэ ургацын ногоо идчихмээр л байна шүү дээ. Энэ жил орон даяар ган болсон. Хүнсний ногоо нь битгий хэл юу ч ургаагүй газар олон байна. Монгол орны хэмжээнд 50 хувь ургац алдсан гэсэн албан бус тоо ч гараад байгаа. Тийм болохоор шинэ ургацын ногоо бага байх нь аргагүй биз. Арай ч нүдний гэм гэж хэлэх нь өрөөсгөл. Гэхдээ л өмнөх жилүүдтэй харьцуулшгүй бага байна. Тиймдээ ч үнэ өртөг нь дийлдэхээ болих шинжтэй. 500 төгрөгийн үнэтэй байдаг төмс 1000-1200 хүрч байна. Лууван, манжин бол ярилтгүй. 2000 давсан, 3000 шахсан үнэтэй байгаа. Одоо яая гэхэв, нэгэнт л ган болж, ургац алдсан хойно. Ногоогоо ургуулсан хэд нь үнэтэй зарах нь зах зээлийн хууль. Гэхдээ зах зээлийн хуулийн хажуугаар манайхны их ашиг олох гэсэн шунаг сэтгэл бас нэрмээс болоод байх юм. Энэ жил Сэлэнгэ зүг рүү гайгүй зун болсон. Хэдийгээр ургац алдсан ч гэсэн яадгаа алдчихаагүй. Гэтэл тэр зүгийн ногоочид төмс, хүнсний ногоогоо намар хямд үнээр зарахгүй гэнэ. Ногоо тарьдаг танил маань ч тийм үг унагаж байна билээ. Тэд намартаа бага сага зараад, ихэнх ногоогоо зооринд дарах бололтой юм. Тэгээд хавар гаргаж ирээд төмсөө 2000, хүнсний ногоогоо 3000 давсан үнээр зарахаар төлөвлөж байгаа гэсэн. Өргөст хэмх, амтат чинжүү гээд нарийн ногоо бол бүр л үнэд орно, ойлгомжтой. Мэдээж зунжин тордож ургуулсан ногоогоо үнэтэйхэн зараад, ахиухан ашиг олохыг хэн хүнгүй л бодож таараа. Тийм болохоор ногоочдыг буруутгах арга байхгүй. Харин энэ сиймхийгээр нь баахан хятад ногоо ороод ирэх вий дээ. Хэдийгээр гаднаас ногоо, оруулж ирэхгүй гэсэн чиглэл салбар яамнаас барих төлөвлөгөөтэй ч яг тулсан газар хэцүү. Зарим байгууллагаас үл хамааран хятад ногоо орж ирэх боломж байгаа. Тэгээд Монголд төмс, хүнсний ногоо хомс өнөө жил бол бүр ч боломжтой шүү дээ. Монголын ногоочид иргэдийнхээ хэрэглээг 100 хувь хангаж чадахгүй, дээрээс нь хэтэрхий үнэтэй зарах гээд байвал хэцүү. Ногоо тарьж ургуулах гэсэн хүмүүсийн хөдөлмөр зүтгэл гэж санаад төмс 1000 төгрөгөөр авч болж байна. Заавал яахаараа төмс 500 төгрөгийн үнэтэй байх ёстой гэж. Тийм биз дээ. Гэхдээ 1000 төгрөгөөс үнэтэй, цаашлаад 2000 -аар зарна гэдэг арай л даварсан хэрэг. Монголынхоо хөрсөнд ургасан, экологийн цэвэр бүтээгдэхүүнийг боломжийн үнээр идчихмээр байна. Тэгээд шинээр нь шүү дээ. Тэгэхгүй хавар гаргаж зарна, үнэд хүргэнэ гэсэн төлөвлөгөөтэй байвал хэрэглээний орон зайг өөр газраас авч л нөхөх болох нь. Ингээд Монголынхоо хэрэглээг өөрсдөө нөхөх гэж зорьж буй зах зээл савлачихвал дахиад тогтворжих гэж хэцүү. Тиймээс хаана хаанаа л бодох хэрэгтэй байна. Шинэ ногоогоо зар, үзэсгэлэнгээ гарга, үнээ ч тогтоо. Ихэнхийг нь хавар зарах гэж нөөцлөөд яахав гэж л хүсэх байна.




УЛС ТӨР

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА



# ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХЭРЭГЛЭГЧИЙН БОЛОВСРОЛ

Б.ЗАЯА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын Хүнсчдийн холбоо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хамтран Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын Үндэсний чуулганыг өчигдөр Төрийн ордны Их танхимд зохион байгууллаа.

Уг Үндэсний чуулганд хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид, төрийн болон ТББ, 21 аймгаас хүрэлцэн ирсэн фермерүүд, малчид, тариалан эрхлэгчид, судлаачид, эмч, эрдэмтдийн төлөөлөл оролцлоо.

Сургуулийн насны 10 хүүхдийн ес нь шүдний өвчтэй, 30-35, 60-65 насны монгол хүний шүд дунджаар 17.2 байгаа нь 80 настай япон хүнийхтэй адил байна. Хэдийгээр японичуудтай өрсөлдөхгүй ч гэлээ бидний аав, ээжүүд бидний үеэс илүү эрүүл чийрэг, "яс сайтай" байна аа гэсэн үг. Сүүлийн жилүүдэд хүн амын дунд зүрх судасны өвчлөл, хоол боловсруулах систем, хорт хавдрын өвчлөл нэмэгдэж, насбаралтын дийлэнх хувь нь хоол боловсруулах системийн өвчлөл, хорт хавдраас шалтгаалж байна. Хорт хавдрын дотор элэг болон ходоодны хорт хавдар хамгийн их буюу 53 хувийг эзэлжээ. Үүнийг өдөр тутам хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал болон эрүүл бус хэрэглээтэй холбож тайлбарлахаас өөр аргагүй юм.

Хүнсний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын тулгамдсан асуудал боллоо... Энэ үгийг бид сүүлийн 15 жил ярьж, бичиж, ширээ тойрон хэлэлцэж байгаа ч ахиц гарахгүй байгааг "Хүнсний аюулгүй байдлын үндэсний чуулган"-ыг санаачлан зохион байгуулсан Монгол Улсын Ерөнхийлөгч, чуулганд оролцож байгаа хүнс үйлдвэрлэгчид нэгэн дуугаар хэлж байна. Хүн амын хүнсний нийт хэрэглээний 50 хувийг импортоор хангаж байгаа үед тухайн улс орныг хүнсний аюулгүй байдлын хувьд "эрсдэлтэй"-д тооцдог аж. Манай улс тэр ангилалд бүртгэгдсээр төдий хугацаа өнгөрсөн гэсэн үг.

Хүнсний аюулгүй байдал гэх энэ ойлголтод хүнсний хангамж, бүтээгдэхүүний аюулгүй байдал, шим тэжээлийн баталгаат байдал гэх гурван зүйлийг зэрэгцүүлж авч үздэг байна. Манай улсын хувьд хүнсний хангамж нь тоон үзүүлэлтийн хувьд хангалттай төвшинд байгаа ч экспорт, импортын зохистой харьцаа алдагдаж, импортоос хараат орны тоонд багтжээ. Гуравхан сая хүн амтай, 80 сая толгой малтай, нэг сая гаруй га тариалангийн газартай улс орны хувьд хүнсний хэрэглээнийхээ тал хувийг гаднаас импортлоно гэдэг "эрсдэлтэй" нөхцөл байдал мөнөөс мөн. Улсын хэмжээнд сүүний нөөц (сүүний гарц болон малын тоо толгойгоор тооцоход) 470 сая тонн гэх боловч Улаанбаатар хот орчимд 140 сая тонн нь эргэлдэж, үүнээс 30 хувийг нь л боловсруулж хэрэглэдэг байна. НҮБ-аас гаргасан зөвлөмжөөр монгол хүн жилд 147 литр (өдөрт 0,5 литрээс илүү) сүүг хүнсэндээ хэрэглэх ёстой ч нийслэлчүүдийн сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ үүний талд нь ч хүрдэггүй.

Өчигдөр Төрийн ордонд болсон "Хүнсний аюулгүй байдлын үндэсний чуулган"-аар хэлэлцсэн гол асуудал нь монгол хүнийг эх орондоо үйлдвэрлэсэн эрүүл чанартай хүнсээр яаж хангах вэ, хүнс үйлдвэрлэгчдээ хэрхэн дэмжиж гадаад зах зээлд гаргах вэ гэдэг асуудал байв. Манай улс 2014 онд 4958 тонн төмс, 2015 онд 720 тонн лууван, 2016 онд 200 тонн төмс, 2014 онд 1460 тонн адууны мах, 360 тонн үхрийн мах, 2015 онд адууны мах 1620 тонн, үхрийн мах 860 тонн, 2016 онд адууны мах 1999,3 тонн, үхрийн мах 600 тонныг ОХУ-д экспортолжээ. БНХАУ руу зөвхөн өнгөрсөн онд үхрийн мах дөрвөн тонн, адууны мах 6460 тонн, ямааны мах 862 тонныг экспортолжээ.

Гэсэн хэрнээ нийслэлчүүд хамгийн өндөр үнэтэй мах идэж, хүнсний ногоогоо импортоор авдаг хэвээрээ. Хөдөөд мал, мах үнэгүйдэж, малчдын амьжиргаа дээрдэхгүй байна гэх атлаа Улаанбаатарчууд махны үнэ дийлдэхээ байлаа хэмээн жагсах. Намартаа хураасан ногоогоо борлуулж чадалгүй үнэгүйдүүлж, өвөл хавартаа Эрээнээс төмс, луувангаа зөөх. Хойд, урд талд нь хоёр том зах зээл байхад монгол мах үнэд хүрдэггүй шалтгаан нь нөгөө л малын эрүүл мэнд. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын дэмжлэгээр энэ талын хууль эрх зүйн зохицуулалтыг хийж хоёр ч хууль баталсан ч малын эрүүл мэнд, мал эмнэлгийн байгууллага нь эрсдэлтэйд тооцогдсон хэвээрээ. Дотооддоо бэлтгэж байгаа мал, махны дийлэх нь үйлдвэрлэлийн бус аргаар буюу гараар бэлтгэгддэг тул эрүүл ахуйн наад захын шаардлага хангадаггүй.

Төмс, хүнсний ногооны бизнес ч бас эрсдэлтэй хэвээр. Дотоодынхоо үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Засгийн газар 1999 онд тогтоол гаргаж, импортын төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэд 5-15 хувийн гаалийн татвар ноогдуулсан ч Хятадын бөөнөөр үйлдвэрлэдэг, өртөг хямд хүнсний ногоотой манай жижиг үйлдвэрлэгчид өрсөлдөж чаддаггүй. Үйлдвэрлэлээ өргөжүүлж, хүчин чадлаа нэмэгдүүлье гээд банкнаас зээл хүсэхээр "танайх ашиггүй ажилладаг" гээд зээл олгодоггүй гэнэ. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан, бондын санхүүжилтээр үйлдвэрлэлээ өргөтгөх, тоног төхөөрөмжөө шинэчлэх хэмжээний зээл авсан ч урсгал зардлаа санхүүжүүлж, ажилчдынхаа цалинг тавьж чаддаггүй. Улирлын чанартай бизнес, үйлдвэрлэлийн гол бэрхшээл энэ. Харин өмнөд, хойд хоёр хөрш маань дотоодынхоо үйлдвэрлэгчдийг хамгаалахын тулд ижил төрлийн импортын бүтээгдэхүүнүүд нь 32 хувийн татвартай байна.

> ...Гэтэл тэр сурталчлаад байгаа бүтээгдэхүүнүүдийн ихэнх нь хэт таргалалт, сахарын өвчин үүсгэдэг гэдгийг тэр бүр анзаардаггүй. Энэ ч бас хүнсний аюулгүй байдал мөн, хувь хүний боловсрол хамгийн чухал гэдгийг чуулганы оролцогчид онцолж байлаа. Хүнсний аюулгүй байдлыг сайжруулахын тулд хүнсний аюулгүй байдал хариуцсан агентлагтай болох ёстой гэдэг байр суурийг ҮАБЗ-ийн ажлын албанаас санал болгов...

Хүнсний аюулгүй байдлын бас нэг чухал зүйл нь бүтээгдэхүүний төрөл ба хэрэглэгчдийн боловсрол. Нэг үеэ бодвол монголчуудын хэрэглээ, амьдралын чанар сайжирч, "мах гурилтайгаа байхад болно доо" гэдэг үе ард хоцорсон. Ядаж л хүн бүрт өдөрт нэг ширхэг өндөг иддэг, хоёр аяга сүү уучихдаг байвал үндэсний хэдэн компаниуд маань босоод ирэхээр байна. Гурван сая хүн шүү дээ. Гэвч дотооддоо үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний нэр төрөл цөөн. Цагаан будаа, элсэн чихэр, ургамлын тос гэхэд 100 хувь импорт. Зөвхөн ургамлын тосыг гэхэд 89 компани импортлодог байна. Тиймээс хөдөө аж ахуйгаа хөгжүүлэхийн тулд хүнсний бүтээгдэхүүнээ төрөлжүүл. Хүнсний бүтээгдэхүүнээ төрөлжүүлэхийн тулд хүнснийхээ хэрэглээг төрөлжүүл гэдэг зөвлөгөөг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын суурин төлөөлөгч Аднан Кэрэши манайханд өгч байна. Үүний тулд эрүүл хүнс, эрүүл хэрэглээг дэмжих хэрэглэгчдийн боловсрол хамгийн чухал нь.

Боловсролын шинэчлэлийн хүрээнд ЕБС-ийн бага ангийнханд "Экологийн боловсрол" гэдэг хичээл орж эхэлсэн. Эрүүл мэндийн боловсрол ч бас уг нь үүнээс хоцрох учиргүй л юм. Барууны орнуудад хүүхдээ сургуульд ороход нь хамгийн түрүүнд барааны шошго уншихаас эхэлж сургадаг гэсэн. Тухайн бүтээгдэхүүн хаана үйлдвэрлэгдсэн, ямар орц найрлагатай, ямар насны, ямар өвчтэй хүнд хориотой гээд. Гэтэл манайд барааны шошго уншдаг хүүхэд байтугай насанд хүрэгчид нь цөөхөн. Ихэнх сайндаа телевизээр рекламдаж байгаа барааг "баталгаатай"-д тооцдог. Гэтэл тэр сурталчлаад байгаа бүтээгдэхүүнүүдийн ихэнх нь хэт таргалалт, сахарын өвчин үүсгэдэг гэдгийг тэр бүр анзаардаггүй. Энэ ч бас хүнсний аюулгүй байдал мөн, хувь хүний боловсрол хамгийн чухал гэдгийг чуулганы оролцогчид онцолж байлаа. Хүнсний аюулгүй байдлыг сайжруулахын тулд хүнсний аюулгүй байдал хариуцсан агентлагтай болох ёстой гэдэг байр суурийг ҮАБЗ-ийн ажлын албанаас санал болгов. Европын холбоо анх байгуулагдаад Хүнсний аюулгүй байдлыг агентлаг байгуулж "Фермерийн хашаанаас хоолны ширээ хүртэл бүх шат дамжлагат аюулгүй байдлыг хангана" гэжээ. Монголчууд энэ тухай л яриад байна. Өчигдөр болсон үндэсний чуулганаас УИХ болон Засгийн газарт хандаж энэ чиглэлээр зөвлөмж гаргав.

Зөвлөмжид, хүнсний аюулгүй байдлын талаар сургалт сурталчилгааг хуулийн хүрээнд үнэ төлбөргүйгээр нийтэлж нэвтрүүлэх, хүнсний шим тэжээлийн тухай хуулийг боловсруулах, хилийн боомт дээрх хүнсний хяналтын лабораторийг чадавхижуулах, хүнсний сүлжээний бүх шат дамжлагуудад зохистой дадлыг хэвшүүлэх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, сүү цагаан идээний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор "Үдийн цай" хөтөлбөрт орох сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээг зааж өгөх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих банкны уян хатан нөхцөлтэй зээлийн системийг судлах, хөрс, усыг бохирдуулж байгаа арьс, ширний үйлдвэрүүдийг Улаанбаатар хотоос гаргах, хэрэглэгчдийн боловсролыг дээшлүүлэхийн тулд ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт оруулах, төрийн болон ТББ-уудын хамтын ажиллагааг сайжруулж, төрийн зарим эрх мэдлийг ТББ-дад шилжүүлэх зэрэг багтсан байна.

Дэлхийн Худалдааны байгууллагаас зөвшөөрсөн хэмжээнд бид дотоодод үйлдвэрлэдэг хүнсний бүтээгдэхүүний импортод 20 хувийн гаалийн татвар тавихад л чамлахааргүй хэмжээний дэмжлэг болно. Манай хоёр хөрш тэгэхэд дотоодынхоо зах зээлийг импортын 32 хувийн татвараар хамгаалж байна. Бид тэдэн шиг хэмжээнд хүргэж чадахгүй юм гэхэд одоо байгаа 5 хувийн татварыг зөвшөөрөгдөх хэмжээ 20 хувьд нь хүргэхэд л үлэмж дэмжлэг болно. Төр нь Үндэсний үйлдвэрлэлээ хамгаалахгүй л юм бол зах зээл тэднийг өмгөөлөхгүй.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Хотын дарга Баянзүрх дүүргийн ИТХ-д хариу хүргүүллээ



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД

МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 7
Утас: 32-71-99, Факс: (976-11) 32-21-47
http://www.ulaanbaatar.mn

2017.09.05 № 01/3049
танай ______ -ны № ______ -т

Хариу хүргүүлэх тухай

Танай 2017 оны 1/428 тоот албан бичиг болон уг албан бичигт хавсаргаж ирүүлсэн Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдааны 14 дүгээр тогтоол, тэмдэглэл, холбогдох бусад баримт бичигтэй танилцлаа.

Уг хуралдаан нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23.7-д "аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын хуралдаанд тухайн Хурлын нийт төлөөлөгчийн олонхи нь хүрэлцэн ирсэн бол хүчинтэйд тооцно" гэж, Улсын дээд шүүхийн 2009 оны "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" 08 дугаар тогтоолын "09"-д "хурлын нийт төлөөлөгч" гэж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас бүрэн эрх нь баталгаажсан нийт сонгогдогчдыг хэлнэ" гэж заасныг тус тус дараахь үндэслэлээр хангахгүй байна. Үүнд:

1.хуралдаанд оролцсон Х.Өлзийхоролыг Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 56 дугаар магадлалаар Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн болохыг тогтоосон тул Баянзүрх дүүргийн Сонгуулийн хорооны 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Х.Өлзийхоролыг Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн нэрийн жагсаалтаас хасаж, 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Баянзүрх дүүргийн 19 дүгээр тойрогт дахин сонгууль явуулахаар шийдвэрлэсэн;

2.хуралдаанд оролцсон А.Эрдэнэсайхан болон түүний сонгуулийн штабын ажилтан С.Түмэннасан нарыг Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр магадлалаар Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн болохыг тогтоосон тул Баянзүрх дүүргийн Сонгуулийн хорооны 2017 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар тогтоолоор А.Эрдэнэсайханыг Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн нэрийн жагсаалтаас хасаж, 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор Баянзүрх дүүргийн 10 дугаар тойрогт дахин сонгууль явуулахаар шийдвэрлэсэн;

3.Сонгуулийн тухай хуулийн 159.4-т "орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх нь хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай сонгуулийн хорооны

D:/2017/Toot/ЗД.docx
111020002053

Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны сонгуулийн үр дүнгийн улмаас дүүргийн Засаг даргын томилгоотой холбогдон үүссэн маргаан өнөөг хүртэл үргэлжилж, тус дүүргийн Засаг дарга албан ёсоор томилогдоогүй байгаа билээ. Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын МАН-ын болон АН-ын бүлэг тус тусдаа хуралдан, өөр өөрийн намаас нэр дэвшигчдийг Баянзүрх дүүргийн Засаг даргад нэр дэвшүүлээд байгаа. Үүсээд байгаа нөхцөл байдлыг хуулийн дагуу шийдвэрлэхээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд өөрийн орлогч Д.Энхтөрийг бие төлөөлөгчөөр томилон, төрийн ажлыг ямар нэг гацаа, чирэгдэлгүй явуулах үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн бөгөөд энэ сарын 5-ны өдрийн 01/3049 тоот албан бичгээр Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хариу хүргүүлсэн байна. Дашрамд дурьдахад, Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зарим төлөөлөгчид сонгуулийн үеэр иргэдийн саналыг татах зорилгоор мөнгө тараасныг шат, шатны Эрүүгийн хэргийн шүүх тогтоожээ.

## Виз мэдүүлэх цагаа утсаар урьдчилж авах боломж бүрджээ

Энэ сарын 11-нээс эхлэн Гадаадын иргэн, харьяатын газар энэ онд дэвшүүлсэн "Цахим иммигрэйшн" зорилтынхоо хүрээнд "Утсаар цаг авах" үйлчилгээ нэвтрүүлжээ. Үйлчлүүлэгчдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлаж, олон улсын жишигт нийцсэн "Утсаар цаг авах үйлчилгээ" ажиллаж буй юм.

Тодруулбал, зөвшөөрөлтэй холбоотой бүхий л үйлчилгээг утсаар цаг авч, дараалалгүйгээр үйлчлүүлэх боломж бүрдэж байгаа юм. "ГИХГ-ын үйлчлүүлэгчид нь гадаадын иргэд, тэр дундаа Монголд хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгч, боловсролын салбарынхан байдаг. Тиймээс тэдний цаг завыг хэмнээд зогсохгүй, аливаа чирэгдлийг багасгах шинэлэг үйлчилгээ нэвтрүүлсэн байна. Виз мэдүүлэх цаг авах иргэд ГИХГ-ын зөвлөгөө мэдээллийн 1800-1882 дугаарын утсаар холбогдож цаг авах юм. Ингэхдээ тус газраас сар хүртэлх хугацаанд багтааж цаг олгох бөгөөд үйлчлүүлэгчид тухайн цагтаа ирээд үйлчилгээгээ авах боломжтой болжээ. Гадаадын иргэд холбогдох хууль, журмын хүрээнд тавьсан шаардлагын дагуу материалаа бүрдүүлсэн байх ёстой аж. Албаныхны мэдээлж буйгаар үйлчлүүлэгчид материалаа дутуу бүрдүүлдэг, чанарын шаардлагад нийцэхгүй зураг өгөх, анкетаа бүрэн гүйцэд бөглөөгүй зэрэг асуудал гаргадаг. Материалын бүрдэл дутуугаас үйлчилгээ удааширч, чирэгдэл үүсдэг талаар хэлж байна. Түүнчлэн утсаар цаг аваагүй хүмүүст урьдын адил дугаар олгож үйлчлэх юм байна. Мөн энэ сарын 20-ноос виз зөвшөөрлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн туршихаар болжээ.

## Сарын дундаж цалин 966 мянган төгрөг болсон гэв

Үндэсний Статистикийн Хорооноос Монголчуудын сарын дундаж цалингийн мэдээллийг гаргасан байна. Нэг хүнд ногдох сарын дундаж цалин 2017 оны хоёрдугаар улирлын байдлаар 966.6 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 78.6 (8.9 хувь) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 7.5 (0.8 хувь) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Харин Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 2017 оны хоёрдугаар улирлын тайланд хамрагдсан 594.9 мянган ажиллагчдын медиан цалин нь 700.0 мянган төгрөг байна. Уул уурхай, олборлолтын салбарт ажиллагчдын сарын дундаж цалин хамгийн их буюу 2221.2 мянган төгрөг байсан бол урлаг, үзвэр, тоглоом наадмын салбарынх хамгийн бага буюу 613.7 мянган төгрөг байна гэдгийг тус тус танилцууллаа.


Реклам, зар сурталчилгааны алба: 99173710

Speak out



# ИРГЭД ЗАСГИЙН ГАЗРЫГ ШУДАРГА ХҮМҮҮСЭЭР БҮРДҮҮЛЭХИЙГ ХҮСЛЭЭ

Э.ТУУЛ

*УИХ-ын сонгуулиар үнэмлэхүй ялалт байгуулсан МАН 404 хоногийн дараа Засгийн газраа огцрууллаа. 2016 оны долдугаар сарын 08-ны өдөр УИХ-ын гишүүдийн 97.1 хувийн саналаар Ерөнхий сайдаар томилогдож байсан Ж.Эрдэнэбат "Эрх мэдлийн төлөө Засгийн газраар туг тахилаа" гэх хатуухан үгийг гишүүддээ хаяглаад ажлаа өглөө. Засгийн газрыг огцруулах тогтоолын төслийг наймдугаар сарын 23-ны өдөр УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан тэргүүтэй МАН-ын 31 гишүүн өргөн барьснаас эхлэн МАН-ын дотоод зөрчил, хагарал, эрх мэдлийн төлөөх дайн олны өмнө ил болж, өнгөрч буй өдрүүдэд эрх баригчдын хэн нь хэн бэ гэдэгт дүн тавих хангалттай шалтаг, шалтгааныг тэд тодоор харуулав. Хуулийн дагуу дараагийн Засгийн газрыг 30 хоногийн хугацаанд бүрдүүлэх учиртай. Харин энэ хугацаанд одоогийн Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ үүрэг гүйцэтгэх юм. Ингээд энэ асуудалд иргэд ямар байр сууръталй байгааг сонирхлоо.*



## Д.Батсайхан: Амьдрал үргэлжилдгээрээ л үргэлжилнэ

*/Хан-Уул дүүрэгт оршин суугч/*

-Муу Засгийн газрыг нэг өдрийн ч өмнө болов унагасан нь зөв. Засгийн газар унаж л байдаг, амьдрал үргэлжилдгээрээ л үргэлжилнэ. Гадны улс орнууд ч Засгийн газраа унагаж л байдаг. Тэглээ гээд ард түмний амьдрал доройтоод, сүйрнэ гэж юу байх вэ. Миний хувьд Ж.Эрдэнэбат танхимаа үлдээгээд л өөрөө огцорчих байсан юм. Тэгээд намын дарга болсныхоо дараа дахиад Ерөнхий сайд болж болох л байсан. Ер нь тэгээд манай улстөрчид төртэй нэг зууралдсан бол тавьж өгөхгүй зууралдаад л байх сонирхолтой байдаг юм байна. Тэртэй тэргүй нэг намын нөхдүүд юмаа мэдэж л байгаа шүү дээ. Бид хамар хашааныхаа айлын амьдралыг мэддэг шиг тэд ч гэсэн нам доторхи зүйлээ мэдэж л байгаа. Тэгэхээр хоосонгүй болоод л огцорсон байх. Саяа ажиллаж байсан танхимаас үлдээх хүн бас бий. Б.Бат-Эрдэнийн тухайд бол сольсон нь зөв. Армид өмнө нь иим ноцтой асуудал гардаггүй байсан. Тэгэхээр дүгнэлт хийгээд огцрох нь зөв. Харин мэргэжлийн хүмүүс ажиллаж байгаа гэж бодвол эрүүл мэнд, боловсролын сайдыг үлдээх нь зөв. Мөн БХБ-ын сайдаар ажиллаж байсан Г.Мөнхбаярыг үлдээх хэрэгтэй. Бусад нь ч хэрэггүй дээ, ардаа том компанитай, ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүсийг солих хэрэгтэй юм. Дараагийн Засгийн газрын тэргүүнээр Ч.Улааныг тавих нь оновчтой болов уу. Эдийн засагч хүн болохоор засгаа аваад явчих боломжтой. Одоо маш хурдан дараагийн Засгийн газраа бүрдүүлэх хэрэгтэй.



## М.Ганболд: Унаад цэвэршиж чадвал сайн хэрэг

*/Сүхбаатар дүүрэгт оршин суугч/*

-Гадаадад хэд хоног ажилтай явж байгаад ирсэн чинь Засгийн газар маань огцорчихож. Ер нь энэ Засгийн газрыг чадваргүй, ажлаа муу хийсэн болохоор л унагаж байгаа хэрэг шүү дээ. Унаад цэвэршиж чадвал сайн л хэрэг. Үр хүүхдэд маань хэрэгтэй гэж би хувьдаа бодож байна. Дараагийн Засгийн газрыг ч чадварлаг, нэр цэвэр хүмүүсээр бүрдүүлэх хэрэгтэй. У.Хүрэлсүхийг гайгүй залуу болов уу гэж харж байна. Засаг төрөө аваад явчих чадвартай л гэж хувьдаа дүгнэж байна даа.



## С.Адъяа: Улсын өр ширийг ч дарсан, ажил хийсэн шүү дээ

*/Сүхбаатар дүүрэгт оршин суугч/*

-Миний хувьд Засгийн газрыг унагасан нь их буруу зүйл боллоо гэж бодож байна. Нэлээд их ажил хийсэн. Улсын өр ширийг ч дарсан, ажил хийсэн шүү дээ. Ер нь төрийн тогтворгүй байдал ард түмний амьдралд ихээр нөлөөлж, доройтуулж байна. Засгийн газраа дахин дахин унагаад байвал ажил ч урагшлахгүй, ард түмний амьдрал ч сайжрахгүй нь үнэн. Тийм болохоор тогтвортой байлгаж, эхлүүлсэн ажлыг нь дуусгуулах хэрэгтэй.



## Б.Сүхбаатар: Улсаа гэсэн сэтгэлтэй, шударга хүмүүс орж ирэх байх

*/Франц улсад оршин суух Монгол Улсын иргэн/*

-Миний хувьд Монголд байдаггүй болохоор нарийн сайн мэдээлэл алга. Ирээд нэг их удаагүй байна. Тэгэхдээ Засгийн газар солигдох нь зөв гэж бодож байгаа. Нэгэнт Монгол Улсын Ерөнхийлөгч маань шударга, сэтгэлтэй хүн болсон болохоор одоо тэр хүнийг л харж байна. Дараагийн Засгийн газарт ч улсаа гэсэн сэтгэлтэй, ажлаа мэддэг, шударга хүмүүс орж ирэх байх гэж найдаж байгаа юм. Ер нь анхнаасаа Засгийн газрыг маш чадварлаг хүмүүсээр бүрдүүлэхгүй бол унах магадлал нь их шүү дээ.



## Ж.Өлзийсайхан: Ж.Эрдэнэбатын Засгийн газрыг базаахгүй юм хийсэн гэж ойлгож байгаа

*/Баянзүрх дүүрэгт оршин суугч/*

-Ажил хийхгүй, ард түмнийг мөлхүүлж байгаа Засгийн газар унахаас өөр яах вэ. Би бол бүрэн дэмжинэ. Төр тогтворгүй байснаар ард түмний амьдрал доройтож байгаа юм. Тэгэхээр төрийн тогтвортой байдлыг хангахын тулд Засгийн газар маш сайн ажиллах ёстой. Нүдэнд харагдаж, гарт баригдах зүйл хийхийг л ард түмэн хүсээд байгаа шүү дээ. Дараагийн Засгийн газарт Ц.Нямдорж, Ч.Хүрэлбаатар нар шиг шударга хүмүүс сайд болох ёстой. Сангийн сайдаар Ч.Хүрэлбаатар, Хууль зүйн сайдаар Ц.Нямдорж нарыг томилох нь зөв. Бусад нь ч мэдэхгүй дээ. У.Хүрэлсүхийн хувьд Засгийн газрыг бариад, чиглүүлээд явахад чадах л хүн гэж бодож байна. Ц.Нямдорж бол Монголдоо №1 улстөрч шүү дээ. Энэ Засгийн газрыг унагахад Ц.Нямдорж зангараг зааж, хамгийн сүүлд гарын үсэг зурлаа. Бидний авч буй мэдээллээр бол Ж.Эрдэнэбатын Засгийн газрыг базаахгүй юм хийсэн гэж ойлгож байгаа. Маш их хэл аманд өртлөө. МАН 65 суудал авсан юм чинь тэд бүгдээрээ л хариуцлагаа хүлээх ёстой. Ард түмний төлөө 65-уулаа л зүтгэх ёстой.



## Ё.Одсүрэн: Нэгэнт цэвэрлэж эхэлсэн учраас бүгдийг нь цэвэрлэх хэрэгтэй

*/Сүхбаатар аймгийн Наран сумын малчин/*

-Мэргэжлийн гэх тодотголтой энэ Засгийн газар анхнаасаа унах нь тодорхой байсан. Үүнийг ч би хувьдаа хүлээн зөвшөөрч байгаа. Учир нь өнгөрсөн хугацаанд Засгийн газрын хийсэн үйлдлүүд, Ерөнхийлөгчийн сонгууль хүртэл асуудал дагуулсан. Монгол Улс маань болохоо болилоо. Тэгэхээр нэгэнт цэвэрлэж эхэлсэн дээрээ бүгдийг нь цэвэрлэх хэрэгтэй. Намчирхах ч хэрэггүй юм. Төрд ажиллаж буй бүх хүн үнэнч шударга байх ёстой. Ерөнхийлөгч оффшорчидтой хатуу тэмцэхээ амласан. Оффшорчдыг олж тогтоон, хариуцлага тооцох хэрэгтэй. 60 тэрбумын асуудалд М.Энхболд, Ц.Сандуй нар орооцолдсон гэдэг нь үнэн шүү дээ. Амьд гэрч байхад худал гээд байдаг нь ямар учиртай юм бэ. М.Энхболдыг унагаад авдаг нь зөв гэж бодож байна. Яг энэ үе дээрээ шударга нийгмийг цогцлоогоод авах нь зөв. Дараагийн Ерөнхий сайдад У.Хүрэлсүхийг дэвшүүлэх нь зөв гэж ярьж байна. Ард түмэн ярьж байгаа бол үнэн. Нийгэм өөрчлөлтийг хүсч байна. Одоо өөрчлөх цаг нь болсон.



## М.Жаргалсайхан: Одоохондоо тэр нь сайн ажиллана гэж нэр заахад бэрх боллоо

*/Сүхбаатар дүүрэгт оршин суугч/*

-Худлаа ярихгүй, үнэнч шударгаар л ажлаа хийх хэрэгтэй байгаа юм. Ард түмэн ч үүнийг л хүсч байна шүү дээ. Засгийн газар нь эргэж буцаад байгаа нь буруу. Унах нь зөв. Хүүхдийн мөнгийг өгнө, өгөхгүй гээд л гадны хүмүүсийн аманд багтаж, ажлаа явуулна гэж байж болохгүй зүйл. Монгол хүн өөрийн ухаанаар, бодлоор ажлаа хийх ёстой атал харийн хүний амаар бүхнийг шийдэж болохгүй биз дээ. Дараагийн Засгийн газар хуулиараа бол 30 хоногийн дотор бүрдэх ёстой. Тэгэхээр Засгийн газарт орж ажиллах хүмүүс шударгаар ажлаа хийж, ард түмнийхээ төлөө ажиллаж, амлалтаа биелүүлэх хэрэгтэй. Одоохондоо тэр нь сайн ажиллана гэж нэр заахад бэрх боллоо шүү дээ. Итгэхэд хэцүү болж байна.



## Д.Маамхүү: Засгийн газрыг унагадаг нь их буруу

*/Сүхбаатар дүүрэгт оршин суугч/*

-Засгийн газрыг унагадаг нь их буруу. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын хувьд залуу хүн, их ч зүйл хийж, зүтгэсэн шүү дээ. Угтаа бол МАН-ынхан өөрсдөө л мэргэжлийн бус Засгийн газарт өөрсдийнхөө хүмүүсийг чихэж оруулчихаад, эцэст нь Засгийн газарт хариуцлага тооцож байгаа нь хамгийн буруу алхам. Ер нь Ж.Эрдэнэбатыг Ерөнхий сайд хэвээр нь үлдээгээд, багийнх нь гишүүдийг сольчихож болдоггүй юм уу. Дараагийн Засгийн газрын тэргүүн болчихоор хүн ер нь л харагдахгүй байна. Худлаа дипломтой болохоос биш сэтгэл, зүрхтэй нь юу л бол. Төр улсаа төвшин тогтвортой байлгах ёстой юм. Тэгэхгүй, ард түмний амьдралыг улам доройтуулж, гадны хөрөнгө оруулагчдыг үргээж, өр зээл дарсан сайн үйлсийг харлуулж байх ямар хэрэг байна. Дараагийн Засгийн газарт үнэхээр итгэх итгэл алга.

## ЭДИЙН ЗАСАГ

Би монголоо ингэж хөгжүүлнэ

# Ч.ХАШЧУЛУУН: НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛ ЦААШИД НЭГ ИХ ТЭЛЭХГҮЙ



**Үргэлжлэл.**
**Түрүүч нь II нүүрт**

**Ухсан нүх, овоолсон шороо хоёр л үлдлээ" гээд байдаг болчихсон шүү дээ?**

-Үнэндээ манай улс 2005 он хүртэл нүүрсээ борлуулж чаддаггүй байлаа. Нүүрс тийм ч их эрэлттэй байгаагүй. Тэр үед томоохон нүүрсний ордууд илэрсэн байсан ч түүнийгээ борлуулж чадахгүй, миний санаж байгаагаар "Үнэгүй аваач" хэмээн том компаниудыг гуйж байсан юм даг. Тухайлбал, Тавантолгойг дэлхийн хамгийн том уул уурхайн компаниудын нэг аваад 2000 оны эхээр "Энэ ерөөсөө бүтэхгүй юм байна" гээд манай улсад үнэгүй буцааж өгч байсан түүхтэй. Тухайн үед манай Засгийн газар Хойд Солонгост хүртэл Тавантолгойг санал болгож байсан ч аваагүй. Иймэрхүү байдал 2006 он хүртэл үргэлжилсэн. Түүнээс хойш экспортлох боломж байгаа юм байна гэдэг нь тодорхой болж эхэлсэн л дээ. Тэгээд яаж экспортлох вэ, яаж борлуулах вэ гэдгийг судалж сонирхсон байгаа юм. Гэхдээ энэ зах зээл дээр гадаадын томоохон компаниуд, хөрөнгө оруулагч нар байдаггүй. Гол тоглогчид манай дотоодын компаниуд байдгаараа онцлогтой гэдгийг би дээр дурдсан.

**-Та түрүүнд дотоодын хэрэглээ нь бага гэлээ. Харин ч хамгийн их хэрэглэгддэг юм биш үү?**

-Дотоодын нүүрсний эрэлт голдуу эрчим хүчний нүүрсэн дээр төвлөрдөг. Эрчим хүчний үйлдвэрлэлд жилд 6-7 сая тонн хүрэн нүүрс хэрэглэдэг. Манайд нүүрс маш элбэг байдаг учраас түүнийгээ нэг бүс нутгаас нөгөө рүү нь зөөнө гэсэн ойлголт байхгүй. Бараг аймаг болгонд нэг уурхай байдаг. Хэрэв уурхайгүй бол хөрш зэргэлдээ аймгаасаа нүүрсээ зөөдөг. Тиймээс гол хэрэглэгч нь манай дотоодын эрчим хүчний шугам сүлжээний систем байгаа биз. Энэхүү эрчим хүчний систем маань 4-5 хэсгээс бүрддэг. Төвийн эрчим хүчний систем, Говийнх тусдаа жижиг дэд станцтай хэсэг байдаг, тэгээд Дорнод төвтэй Зүүн бүсийн эрчим хүчний систем, мөн Хангайн болон Баруун бүсийнх байна. Гэхдээ сүүлийн жилүүдэд манай улсын эрчим хүчний хэрэглээ өсөх хандлагатай байгаа. Одоогийн байдлаар нийт эрчим хүчнийхээ 90 хувийг нүүрсээр үйлдвэрлэж байна. Үлдсэн цөөн хувийг нь усан цахилгаан станцаар үйлдвэрлэж байгаа. Энэ нь баруун бүсэд амжилттай хэрэгжиж байна. Бид бас хоёр хөршөөсөө цахилгаан импортолдог. Оюутолгойн үйлдвэрийн хэрэгцээнд урд хөршөөс, хойд хэсгийн бүс нутаг ОХУ-аас цахилгаан импортолдог. Гадагшаагаа нэлээд мөнгө төлж байж цахилгаан авч байна. Гэхдээ манай төрийн өөрийнх нь сонирхол аль болох гадаадаас эрчим хүч авахгүй байх, эрчим хүчээр өөрийгөө бүрэн хангах зорилготой байдаг юм. Гэтэл эрчим хүчний шугам сүлжээний таван бүс маань хоорондоо бараг холбогдоогүй гэдгээрээ онцлогтой. Яагаад гэвэл, манай орны газар нутаг өргөн уудам, хоорондоо хол зайтай. Хэрэв хооронд нь холбоё гэвэл маш урт дамжуулах сүлжээ буюу хар яриагаар маш олон шонгийн мод тавих хэрэгтэй болно. Энэ нь маш өндөр өртөгтэй байдаг. Гэхдээ цаашид таван сүлжээгээ хооронд нь холбоод нэг газарт нь илүү тог байвал түүнийгээ өөр газар руу шилжүүлдэг болж болно. Энэ нь урт хугацаанд хийгдэх ажил. Яваандаа зөвхөн нүүрс биш салхи, нар, бусад төрлийн эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх зорилго ч бий. Жишээ нь, сэргээгдэх эрчим хүчээр нийт эрчим хүчний хэрэглээний 30 хувийг үйлдвэрлэх зорилттой явж байгаа учраас Өмнөговь, Сайншандад нар, салхины станц баригдаж байна. Саяхан Дарханд ийм станц барьсан. Дараа нь Улаанбаатар хотын ойролцоо барих төлөвлөгөөтэй юм билээ. Гэхдээ усан цахилгаан станц дээр ил, далд хэлбэрээр маш их тэмцэл өрнөж байдаг. Тэр нь цахилгаан гэхээсээ илүү устай холбоотой асуудал байдаг юм.

> ...Жишээ нь, сэргээгдэх эрчим хүчээр нийт эрчим хүчний хэрэглээний 30 хувийг үйлдвэрлэх зорилттой явж байгаа учраас Өмнөговь, Сайншандад нар, салхины станц баригдаж байна. Саяхан Дарханд ийм станц барьсан. Дараа нь Улаанбаатар хотын ойролцоо барих төлөвлөгөөтэй юм билээ. Гэхдээ усан цахилгаан станц дээр ил, далд хэлбэрээр маш их тэмцэл өрнөж байдаг...

**-Ус аа, яагаад нүүрс маань ус болоод "урвал"-д орчихов оо?**

-Монгол Улсын хувьд ус бол маш чухал нөөц. Энэ нөөц маш их хэмжээгээр багасч байгаа. Дэлхийн дулаарлаас эхлээд маш олон шалтаг тоочиж болно. Дээрээс нь бид маш их хэмжээний усыг хилээрээ алдаж байгаа юм. Ерөөсөө ашиглаж чаддаггүй. Гэтэл манайд ус их хэрэгтэй. Уул уурхайн томоохон үйлдвэрлэл, хөдөө, аж ахуйн салбарт ч ус хэрэгтэй. Тиймээс усаа тодорхой хэмжээгээр дотоoддоо хэрэглэх ёстой. УИХ-аас 2010 онд баталсан усны бодлогын баримт бичгийн гол санаа нь энэ. Монгол Улс усаа дотооддоо байлгах зорилготой. Ингэж усыг их хэмжээгээр дотооддоо үлдээхийн тулд бидэнд хадгалах усан сангууд хэрэгтэй юм. Усан санг ихэвчлэн усан цахилгаан станцтай хамтад нь барьдаг. Яагаад гэвэл, усан цахилгаан станцын хажууд усан сан үүсдэг. Өөрөөр хэлбэл, усан сангуудыг үүсгэхийн тулд усан цахилгаан станц барьж байгаа юм, миний бодлоор. Манай улс аж үйлдвэрээ хөгжүүлье л гэж байгаа юм бол хямдхан цахилгаан үйлдвэрлэх усан цахилгаан станцтай болох хэрэгтэй. Би нэг жишээ хэлье л дээ. Манай Сэлэнгийн ус хойд хилээр гараад Байгаль нуурт цутгаж байгаа. Гэтэл Байгаль нуур дээр тэр усыг асгадаг дөрвөн том усан цахилгаан станц байна. Тэр дөрвүүлээ төрийнх биш хувийн өмч. Оросын тэрбумтан Олег Дерипаскагийнх. Дерипаска хямд цахилгаан үйлдвэрлээд өөрийнхөө үйлдвэрт хямд үнээр нийлүүлдэг. Тиймээс манай улс усан цахилгаан станц барьвал тийшээ очих усны хэмжээ ямар нэгэн байдлаар багасна гэж бодоод байгаа юм. Энэ нь Байгаль нуурыг хамгаалж байгаа хэрэг огт биш. Тэгсэн мөртлөө цөлжилттэй байгаа Монгол Улсыг ус битгий ашигла гээд байдаг. Тэгж ярьвал бид усныхаа 10 орчим хувийг нутагтаа үлдээгээд ашиглах бүрэн эрхтэй шүү дээ.

**-Гэтэл манайхан нүүрсээ угааж, нэмүү өртөг шингээж ч чадахгүй түүхийгээр нь гаргаж байна?**

-Нүүрс угаах хоёр үйлдвэр байдаг, манайд. Шарын голд нүүрс боловсруулах жижигхэн үйлдвэр бий. Нөгөөдөх нь "Энержи ресурс" дээр байдаг юм. Нүүрс шороо чулуутай холилдсон байдаг. Үүнийг хаа нэгтээ цэвэрлэх л хэрэгтэй болно. Угааж цэвэрлэснийг нь боловсруулсан нүүрс гэж байгаа юм л даа. Манайд нүүрсээ угаалгүй гаргадаг компаниуд ч бий. Яагаад гэвэл, нүүрс угаахад тоног төхөөрөмж, тэгээд ус хэрэгтэй.

**-Бид гадаад ертөнцөд хэл ам татлан байж усан цахилгаан станц барих нь байтугай дотооддоо ганц цахилгаан станц барьж чадалгүй олон жил боллоо. Алдарт V цахилгаан станц ашиглалтад орох нь хэзээ юм бол доо, мэдэхгүй?**

-Одоо байгаа дөрвөн станц нийслэлийг цахилгаан, дулаанаар хангаж дөнгөөд байгаа ч яваандаа дулаан хүрэлцэхгүй. Бүр цахилгаанаас илүү дулаан нь эрэлттэй болно. Тийм учраас л V цахилгаан станцыг барья гэж ярьдаг. Одоохондоо III, IV цахилгаан станцаа өргөтгөөд дулааныг үйлдвэрлэчихнэ гэдэг төлөвлөгөөтэй яваад байна. Цаашид Улаанбаатарт төдийгүй Өвөрхангай, Хэнтий, Завхан, Архангай, Дундговь, Төв, Говь-Алтай аймагт гээд хэд хэдэн дулааны станц барих шаардлагатай болно. Бүгдээрээ л нүүрсний ордоо түшиглэж баригдана байх. Манайх бол маш их нүүрсний нөөцтэй. Хэдэн мянган жил хэрэглэхэд ч хүрнэ. Дээрээс нь шинэ ордууд илэрсээр байгаа. Ер нь уул уурхайн салбарын хувьд манай зүүн болон төвийн бүсийг л судалсан байдаг. Баруун бүсийг судалж бараг чадаагүй. Тэнд юу байгааг хэн ч хэлж мэдэхгүй. Дахиад нэг Тавантолгой юм уу Оюутолгой байхыг үгүйсгэхгүй. Хайгуулын ажил хийгдэж л байгаа. Тиймээс нүүрсний нөөц одоо байгаа дээрээ нэмэгдэх бүрэн боломжтой.

**-Бараа бүтээгдэхүүн байлаа ч түүнийгээ борлуулж чадахгүй бол эдийн засгийн үр ашиггүй, ямар ч өгөөжгүй л гэсэн үг биз дээ?**

-Манай улсын хувьд экспортын зах зээл их муутай газар. Хойд хөрш ОХУ манай экспортолж байгаа нүүрснээс 10 дахин их нүүрсийг Хятад руу экспортолдог. Тийм учраас нүүрсний зах зээл дээр хойт хөрштэйгөө заримдаа өрсөлдөгч болчихдог юм. Өөрөөр хэлбэл, манай хоёр улс Хятад гэсэн ганцхан зах зээлтэй. Хятадын компаниудын хувьд Оросоос авах, Монголоос авах төдийлөн ялгаагүй. Монголын нүүрсний экспорт 2015 онд 13 сая тоннд хүрч байлаа. Гэхдээ энэ нь тийм ч өндөр тоо биш. Зарим үед 20-30 сая тонн хүрэх боломжтой. Ер нь манайд боломж их. Жилд 60 сая тонн нүүрс гаргасан ч чадна, уг нь. Гэхдээ худалдан авах зах зээл нь ганцхан шүү дээ. Тэр нь хямарчихвал худалдан авалт тэр хэмжээгээр багасна. Хятадын өөрийнх нь нүүрс олборлох хүчин чадал Монголоос 100 дахин их байдаг. Түүнийгээ дотоодын зах зээлдээ яаж борлуулах вэ гэж толгойгоо гашилгаж суудаг байхгүй юу. Хоёрдугаарт, Хятадын дулаан, цахилгааны дийлэнх эх үүсвэр нүүрсээр ажилладаг учраас их утаатай байдаг. Тиймээс тэнд утааг багасгахын тулд нүүрсний эрчим хүчний хэрэглээг багасгах бодлого барьж байна. Цахилгаан станцуудынхаа заримыг нь хаасан. Манай эрчим хүчний нүүрсний экспорт яваандаа багасах төлөвтэй юм байна гэдэг нь эндээс түвэггүй харагдана. Хятадууд жилд 200 сая орчим тонн нүүрс импортолдог. Түүний тавны нэг нь төмөрлөгийн хэрэгцээнд шаардлагатай коксжих нүүрс байгаа. Үүний тавны нэгийг 2015 онд Монгол Улс нийлүүлж байсан. Бусдыг нь Австрали, ОХУ зэрэг томоохон тоглогчид гаргаж байсан. Ер нь одоо энэ зах зээл тийм ч их тэлэхгүй болов уу. Сүүлийн жилүүдэд манай экспорт огцом буурч байгаа. Үнэ нь ч их хэмжээгээр унасан. Энэ цохилтоос Монголын нүүрсний салбар амьд гарсан л даа. Гэхдээ их хүнд нөхцөлд орсон. Энэ үед Америкийн зарим компани дампуурсан. Жишээ нь, манайд үйл ажиллагаа эрхэлж байсан "Пийбоди" дампуурсан. Хятад, Австралид их олон уурхай хаагдаж байлаа. Харин манай улсад уурхайнууд хаагдаагүй ч гэсэн экспортын хэмжээ эрс буурсан шүү дээ. Ийм нөхцөл үүсэх шалтгаан нь нэлээд хэдэн жилийн өмнөөс бүрэлдсэн.

**-Манай улс энэ жил хэчнээн сая тонн нүүрс олборлох бол?**

-Энэ жил манай улс 31 сая тонн нүүрс олборлох байх гэж төсөөлж байна. Эндээс 23 сая тонныг нь экспортод гаргаад 8.3 сая тонныг дотооддоо хэрэглэнэ байх. Мэдээж, энэ тоо дахиад шинэчлэгдэнэ. Нүүрсний үнэ ч хэлбэлзэнэ. Үүнд нөлөөлж буй хамгийн том хүчин зүйл нь дэлхийн эдийн засаг аажим аажмаар ногоон тал руугаа явж байгаа. Нэг өдрийн дотор бүгдээрээ ногоорчихгүй ч энэ өөрчлөлт алгуурхан хийгдсээр л байна.


## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь "2 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн байрны өргөтгөлийн барилгын зураг төсөв хийх" зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь: Налайх дүүргийн 2 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн байрны өргөтгөлийн барилгын зураг төсөв хийх боловсруулах болно.

2. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (нийтлэл, ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл гэх мэт) ирүүлнэ.

3. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр хүртэл авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 11:00 цагийн дотор ирүүлнэ үү.

**Налайх дүүрэг, 2-р хороо, Хуульчдын гудамж,**
**Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын байр,**
**Худалдан авах ажиллагааны алба, утас 70232788**

# ОРОН НУТАГ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

## Н.БЯМБАЦЭЦЭГ: "ДОРНОГОВЬ ТҮНШЛЭЛ-2017" ҮЗЭСГЭЛЭНГ ЭХЛЭЭД АЙМАГТАА ЗОХИОН БАЙГУУЛНА



Г.ГАНЧИМЭГ

*Тус аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Н.Бямбацэцэгтэй өвөлжилтийн бэлтгэл ажил, удахгүй болох үзэсгэлэн худалдааны талаар ярилцсан юм.*

**-Налгар сайхан байгаа хэдий ч намрын сар зургаа биш гэдэг дээ. Өвөлжилтийн бэлтгэл ажил ямар шатандаа яваа бол?**

-Дорноговь аймгийн 2016-2017 оны өвөлжилтийг өнтэй сайхан давсан. Зун долдугаар сарын 20-ноос хойш аймгийн нийт нутгаар ихээхэн хэмжээний бороо орсон юм. Ойр ойрхон бороо орсны хүчинд зуны эхэн сард нэлээд гандуу байснаа бодвол нийт нутгаар ногоорч, зуншлага сайхан боллоо. Гэхдээ Ус, цаг, уур, орчны шинжилгээний газраас бэлчээрийн төлөв байдлыг 14 сумын 53 багт ургацаар нь тодорхойлдог. Үүгээр нийт нутгийн 24 хувьд нь зуншлага хэвийн, 37 хувь нь гандуу, 39 хувь нь гантай гэж гарсан. Энэ судалгааг хийсний дараа бас бороо орсон байгаа. Малчид, иргэдийн ярьж байгаагаар бол зуншлага өмнөх жилүүдээ бодвол хамгийн сайхан жил боллоо. Сүүлийн жилүүдэд "Өвөл зуд болно" гэдэг ам дамжсан яриа их гардаг болсон л доо. Хэдий тэгж ярьдаг ч говьд сүүлийн хэдэн жил өвөл өнтэй сайхан л байна. Гэхдээ их хүйтэрч магадгүй гэж яриад байгаа учраас хүмүүс өвөлжилтийн бэлтгэлээ маш сайн базааж байгаа. Монгол Улсын Засгийн газрын 186 дугаар тогтоол гарсан. Үүгээр аймаг, сумын хэмжээнд хэдэн тонн өвс, тэжээл бэлтгэх ёстой вэ гэдэг бүх норм өгөгддөг. Үүний дагуу бүх сум өвөлжилтийнхөө бэлтгэл ажлыг хангаад эхэлчихсэн. Аймгаас гурван хадлангийн салааг Сүхбаатар, Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт байгалийн хадлан бэлтгүүлэхээр гаргалаа. Одоогоор аймгийн нөөцөд 82.6 тонн өвс хадгалагдаж байна. Өнгөрсөн хавар "Хаваржилт хүндэрлээ" гэдэг ам дамжсан яриа гарч, малчид "Үнэ төлбөргүй өвс өгөөч" гэдэг хүсэлт ирүүлсэн. Аймгаас 14 мянга гаруй боодол өвсийг алслагдсан байдал, малын тоо зэргийг харгалзан сумдад хуваарилсан юм. Энэ өвсийг суманд татаж аваачаад малчдад тараах үед ногоо гарч эхэлсэн. Тэгээд хүйтэрч, хүндэрч магадгүй гээд байсан цаг хугацаа нь өнгөрсөн л дөө. Тиймээс малчид "Үнэ төлбөргүй өгье" гэсэн ч энэ өвсийг аваагүй байна. Одоо бүгдээрээ сумын нөөцөд хадгалагдаж байгаа юм. Гэхдээ энэ жил аймаг норм, төлөвлөгөөнийхөө дагуу өвөлжилтийн бэлтгэлээ хангаж, өвс тэжээлээ татаж авч нөөцөлнө.

**-Аймгийн хэмжээнд хэдэн малчин өрхийн хэчнээн толгой мал өвөлжиж, хаваржих бол?**

-Манай аймаг 2016 оны жилийн эцсийн мал тооллогоор 1.7 сая толгой мал тоолуулсан. Одоогоор 4137 малчин өрхийн 1.7 сая толгой мал өвөлжиж, хаваржих урьдчилсан төлөвтэй байна.

**-Хөдөө аж ахуйгаас гадна өөрийн чинь хариуцдаг бас нэгэн салбар бол жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа юм байна. Төр, засгийн зүгээс жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ гэж ярьж байгаа. Дорноговь аймгийн хувьд энэ салбарын хөгжил ямар байна вэ. Хөндлөнгөөс нь харахад хилийн хоёр боомттой, дэд бүтэц сайн хөгжсөн гээд давуу тал олонтой юм?**

-Жил бүр аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, бодлогын баримт бичгүүдэд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлогын зорилтууд тусгагддаг. Манайд томоохон гээд нэрлэчих үйлдвэр байхгүй. Уул уурхайн компаниуд бол бий. Том үйлдвэр байдаггүй, дандаа өрхийн хэмжээний жижиг үйлдвэрлэл эрхэлдэг. Сум хөгжүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр тодорхой хэмжээний санхүүжилтийг жил бүр өгдөг. Сүүлийн үед баримталж буй бодлого, чиг хандлага нь бараа, бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд гаргах, аялал жуулчлалын салбартайгаа уялдаа холбоотой ажиллаж, жуулчид ямар бүтээгдэхүүнийг илүү сонирхож байна вэ гэдгийг судалж, туршлага хуримтлуулах оролдлогыг хийж байна. Манай аймаг БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Дарханмуумянган хошуу болон Эрээн хоттой хамтын ажиллагаатай. Газар зүйн байрлалын хувьд ч хөрш зэргэлдээ. Тиймээс жил бүр хамтраад үзэсгэлэн худалдаа зохион байгуулахаар хэлэлцсэн. Энэ хэлэлцээнийхээ дагуу өнгөрсөн хавар Эрээн хотод үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, 70 орчим иргэн, аж ахуйн нэгж 30 орчим тонн бараа бүтээгдэхүүн авч явсан. Ийм хамтын ажиллагааныхаа хүрээнд энэ сарын 20-нд Дарханмуумянган хошуунд "Дорноговь түншлэл-2017" үзэсгэлэн худалдааг зохион байгуулах гэж байна.

> ...Манай бизнес эрхлэгчид ч эхний ээлжинд Эрээн эсвэл Дарханмуумянган хошуу, бүр Хөх хот руу явах сонирхол маш их. Гэхдээ манайханд нэг сул тал бий. Өөрсдийнхөө үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний хаяг, шошго, сав, баглаа, боодол, чанарыг маш сайн анхаарах хэрэгтэй...

**-Энэ үзэсгэлэн худалдаанд оролцох хүмүүсийг ямар шалгуураар сонгох вэ. Магадгүй очих газрынхаа онцлогоос болоод ямар бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хүнийг авч явах вэ гэх мэтээр нарийн асуудлууд бий л байх?**

-Дарханмуумянган хошуу, Эрээн хот хоёр ялгаатай. Дарханмуумянган хошуу хүн амаараа Эрээн хоттой ойролцоо боловч малчин иргэд олонтой. Тиймээс бидний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг илүү сонирхдог юм билээ. Ялангуяа, мах, махан бүтээгдэхүүнийг жилийн дөрвөн улиралд авах сонирхолтой байдаг. Гэтэл манай талд үүсээд байгаа нөхцөл байдал буюу малын гоц халдварт өвчин шүлхий, цэцэг, мялзан зэргээс болоод хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгогддоггүй. Манай бизнес эрхлэгчид ч эхний ээлжинд Эрээн эсвэл Дарханмуумянган хошуу, бүр Хөх хот руу явах сонирхол маш их. Гэхдээ манайханд нэг сул тал бий. Өөрсдийнхөө үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний хаяг, шошго, сав, баглаа, боодол, чанарыг маш сайн анхаарах хэрэгтэй. Чанарын шаардлага хангахгүй, стандартад нь нийцэхгүй, тэгээд хэт өндөр үнэтэй бараа, бүтээгдэхүүнийг зарах гэж зарим нь оролддог. Эрээний томоохон захууд дээр яг ижил төрлийн бүтээгдэхүүн хямд үнэтэй байх жишээний. Гэтэл манайхан тэнд 1000 гэж байвал 2000-3000 төгрөгөөр зарах гээд байдаг. Бид үзэсгэлэн худалдаанд оролцож буй хүмүүстээ энэ талаар анхааруулж, заавар зөвлөгөө өгч, туршлага судлуулдаг юм. Энэ сарын 15, 16-нд аймагтаа эхлээд үзэсгэлэн худалдаа зохион байгуулна. Аймаг, орон нутгаас санхүүжилтийг нь шийдвэрлэдэг. Жил бүр зохион байгуулдаг уламжлалтай. Хүмүүсийн дунд хүлээлт үүсгэдэг томоохон арга хэмжээ болчихсон. Үүнд 14 сум зохион байгуулалттай оролцож, бараа бүтээгдэхүүн, сумаа сурталчилдаг. Эндээс шалгарсан оролцогчдын зардлыг нь даагаад улсын хэмжээний арга хэмжээнд явуулдаг. Үүнээс гадна энэ онд зарласан "Бүтээн байгуулалтын жил"-ийн хүрээнд худалдааны төвүүдийн тохижилт, өнгө үзэмжийг сайжруулах талаар нэлээд анхаарч ажиллалаа.

Аймгаас мэдээлж байна

СЭЛЭНГЭ АЙМАГ

### Засаг даргын дэмжлэгтэйгээр 10 өрх орох оронтой болжээ

Сэлэнгэ аймгийн Улаан Загалмай Хороо нь ард иргэдийн дунд байгалийн гамшиг гэнэтийн осол аюулаас урьдчилан сэргийлэх талаар сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж, болзошгүй гамшгийн үед ажиллах нөхөрлөлийг байгуулж, гамшигт өртөгсдөд эд материалын болон сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж ажилладаг. Тус хороотой аймгийн Засаг дарга хамтран ажиллах гэрээ байгуулан гамшгийн нөөц сан бүрдүүлэн ажиллаж байгаа юм. Сэлэнгэ аймгийн Засаг даргаас энэ оны эхний найман сарын байдлаар 8.36 сая төгрөгийн санхүүжилтийг олгосноор Алтанбулаг, Цагааннуур, Сүхбаатар, Баруунбүрэн, Хушаат, Сайхан, Хүдэр, Жавхлант сумдын иргэдэд тус бүр нэг, Сант сумын хоёр иргэн, нийт 10 айлыг орон гэртэй болгох ажлыг аймгийн Улаан Загалмайн Хорооноос зохион байгуулаад байна.

Сэлэнгэ аймгийн Улаан Загалмай Хороо нь 2016-2017 оны өвөлжилт хүндэрсэн цаг үед нэлээд ажил хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал, малчдад туслах аяныг зохион байгуулснаар хоёр сая гаруй төгрөгийн тусламж малчдад олгож, ОУУЗУХСХ, МУЗН хамтран үнэлгээ хийж, хүмүүнлэгийн тусламж үзүүлснийг хүлээлгэн өгчээ. Дээрх хүмүүнлэгийн тусламжид 16 сумын 392 өрх хамрагдаж өрх бүрд 245000 төгрөгийн бэлэн мөнгөний тусламж, 96 сая төгрөгийн тусламж болон малын тэжээл хуурай сүү зэргийг олгосон байна. Энэхүү тусламжийг ОУУЗХ-ны шаардлагын дагуу 200-аас доош малтай, нийгмийн эмзэг бүлэгт хамрагдах өрхийн гишүүдтэй /60-аас дээш насны өндөр настан, өрх толгойлсон эцэг, эх, 16-аас доош насны олон хүүхэдтэй өрх, гэр бүлийн гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй/ айлуудад шалгуур үзүүлэлтээр сонгож олгожээ. Мөн ОУУЗХ-ны санхүүжилтээр "Хөдөө орон нутгийн малчид болон хот суурин газрын гамшгийг даван туулах чадварыг бэхжүүлэх" төслийн хүрээнд Хүдэр, Алтанбулаг сумдад нийтийн оролцоотой гал унтраах "Усан хөөрөг"-ийг "Есөн Хэлхээ"ХХК-иар хийлгэж, ОУУЗХ-оос "Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах" төслийн хүрээнд Сайхан сумын "Таван эрдэнэ" малчны бүлгийг дэмжин өвөлжөө бариулж тус бүрт хүлээлгэн өгчээ. Мөн аймгийн Улаан Загалмай Хорооноос 13 сумын 250 өрхөд 1250000 төгрөгний тусламжийн хувцсыг олгосон байна.

Одоо ОУУЗХолбооны санхүүжилтээр олон нийтийн оролцоотой гал унтраах бэлэн байдлын кабинет тохижуулж, гал унтраах хэрэгсэлүүдийн хамт Хүдэр, Алтанбулаг суманд хүлээлгэж өгөхөд бэлэн болгоод байгаа ажээ.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

### "Амар тайван Сүмбэр" аяны нээлт боллоо




Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, аймгийн Цагдаагийн хэлтэс хамтран "Амар тайван Сүмбэр" аяныг зохион байгуулж байна. Аяны нээлт Боржигин чуулгын өмнөх талбайд өчигдөр болж Сүмбэр сумын ИТХ-ын дарга Т.Түмэнбаяр цугларсан иргэд хөдөлмөрчдөд хандан мэндчилгээ дэвшүүлж, аяндаа идэвхи санаачлагатай оролцохыг уриаллаа. Нээлтийн үйл ажиллагаанд дуу бүжгийн Боржигин чуулгын уран бүтээлчид ая дуугаа өргөснөөс гадна Цагдаагийн хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн Ахлах мөрдөгч цагдаагийн ахмад М.Баярзолбоогоор ахлуулсан албан хаагчдын үзүүлэх тоглолт мөн Замын цагдаагийн тасгийн үзүүлэх тоглолтууд тус тус боллоо. "Амар тайван Сүмбэр" аян 45 хоногийн хугацаатай үргэлжлэх бөгөөд иргэдийн амар тайван аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, шинээр батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжуудыг сурталчилан таниулахад аяны гол зорилго оршиж байгаа юм. Аяны хугацаанд нийт 18 ажлыг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гаргажээ.

ОРХОН АЙМАГ

### Бүтээн байгуулалтад 17 тэрбум төгрөг зарцуулжээ

"Энэ жил Орхон аймагт орон нутгийн төсвийн 17 тэрбум төгрөгөөр 257 нэр төрлийн ажил гүйцэтгэж байна. Үүнээс барилга угсралтын ажил 59, тохижилтын 15, дээвэр засварын 55 ажил хийж гудамж талбайд шинээр 149 гэрэл суурилуулсан байна.

Мөн автозам дагуух 502 гэрэлтүүлгийг лед гэрлээр сольж 5.9 км кабел шугам засварласан гэж Хот байгуулалт барилга, захиалагчийн албаны мэргэжилтэн "Барилгачдын баяр"-ын хурлын үеэр мэдээллээ. Энэ жилийн бүтээн байгуулалтын ажилд иргэдийг татан оролцуулсан нь иргэд түр ажлын байраар хангасныг онцоллоо. Тухайлбал, 12139 м2 талбайд явган хүний зам хийхдээ иргэдийн 23 бүлэг ажиллуулсан байна. Энэ жил 6524 м2 бетонон зам, 14000 м2 сайжруулсан шороон зам хийжээ.

Дашрамд дурдахад, 2015 онд тус аймагт 142 ажилд 23.7 тэрбум, 2016 онд 227 ажилд 19.4 тэрбум төгрөг зарцуулсан байна.

# ЗАВСАРЛАГА

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр +20
Шөнө +9

Нөгөөдөр
Өдөр +14
Шөнө +8

## Өдрийн зурхай

**НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР**

**Үс засуулбал:** *Эд эдлэл идээ ундаа олдоно.*
**Наран ургах, шингэх:** *06.33-19.09*



Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба гарагийг тахих, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, улаа гаргах, хиншүү хярвас гаргах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, эдлэл, идээ, ундаа олно.

ОНЦЛОХ МЭДЭЭ




## НАЙМДУГААР САРЫН ШИЛДЭГ ТАМИРЧИН ХЭН БЭ?

Монголын Үндэсний Олимпийн Хорооноос тухайн сард болж өнгөрсөн уралдаан тэмцээнд өндөр амжилт үзүүлж, эх орныхоо нэрийг дэлхийн тавцанд өргөсөн тамирчид, багийг алдаршуулах, сар бүр Монголын спортын ертөнцөд болсон үйл явдлыг дүгнэх зорилгоор “Сарын шилдэг тамирчин”-г тодруулж эхэллээ.

“Сарын шилдэг тамирчин”-г спортын сэтгүүлчид болон олон нийтийн нээлттэй санал асуулгын үр дүнд тодруулах бөгөөд шалгаруулалтыг сар бүрийн эхний хагаст явуулах болно.

Та бүхэнд наймдугаар сарын шилдэг тамирчинд нэр дэвшигчдийг танилцуулж байна.

### Сарын шилдэг тамирчин тодруулах журам

*Сар бүрийн эхний хагаст тодрох сарын шилдэг тамирчинг тодруулахдаа дараах зарчмыг баримтална.*

Спортын сэтгүүлчдийн санал -50 хувь /Монголын спортын сэтгүүлчдийн холбоотой хамтран/
Онлайн санал асуулга - 50 хувь /цахим сайтууд, бусад онлайн хэрэгслүүдээр/
Энэ сарын шалгаруулалт есдүгээр сарын 15 хүртэл үргэлжлэх бөгөөд шилдэг тамирчны шагналыг есдүгээр сарын 18-нд гардуулна гэж МҮОХ-ноос мэдээллээ.

Books “Ном” буланд тавтай морил

## ИХ ГЭРИЙН ЭЗЭГТЭЙ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь №154 дугаарт**

Дараа нь хоёул хамжин салны нөгөө талаас өргөсөнд бөөрөнхий модон дээгүүр сал амархан гулсав. Салны доороос бөөрөнхий мод гарч, дахиад эхнээс нь давтан хийлээ. Энэ бол хамаг тэнхээ барсан хүнд ажил болохоор салыг усны хөвөөнд аваачих үед хөлөрсөн нүүр нь гялалзаж байлаа. Энэ бүх ажилд Жемийн бодож төлөвлөснөөс ч их цаг орж, үүр цайх ойртжээ. Тэр хоёр даруйхан хөдлөх хэрэгтэй байв. Эс тэгвэл тосгоны хэн нэг нь тэднийг хараад эрх баригчдад ховлон мэдүүлнэ. Жеми дарвуулыг хурдан дэлгэж, бүх бэхэлгээг шалгалаа. Нэг юм мартсан шиг санагдаад сэтгэл нь амарч өгөхгүй байв. Гэвч тэр юунд сэтгэл зовоод байгаагаа гэнэт ойлгоод тас тас хөхрөв. Банда өөдөөс нь гайхан харж,

-Юу нь инээдтэй байна?

-Урьд нь би бүтэн тонн багаж хэрэгсэл аваад алмас эрэхээр явж байсан. Одоо бол ганц луужин л байна. Энэ бүгд дэндүү амархан ажил шиг санагдаад... гэхэд нь Банда,

-Удахгүй чиний бодол өөр болох байх аа, Макгрегор... гэж тэрбээр аяархан өгүүлэв.

-Чи намайг зүгээр Жеми гэж дуудах цаг болсон баймаар юм... гэсэнд Банда гайхан толгой сэгсэрч,

-Чи нээрээ алс холоос ирсэн хүн... гээд дун цагаан шүд яралзуулан инээмсэглэж,

-За яах вэ, эцсийн бүлэгт нэг үхэхээс хоёр үхэх биш... гээд нэрийг нь амталж үзэж байх шиг уруулаа өмөлзүүлэн дараа нь,



-Жеми... Алмас олох аян замдаа орох боллоо... гэв.

Хоёул салаа гүехэн усанд түлхэн оруулаад өөрсдөө дээр нь харайн гарч, сэлүүрдэж эхэллээ. Салаа жолоодож сурахад нь хэдэн минут хэрэгтэй болов. Тэд асар том бөглөөн дээр хөвж явах шиг санагдав. Юутай ч хөвж байлаа. Тэнгисийн урсгал завийг умард зүг рүү урсгана. Жеми дарвуулаа босгоод завиа задгай тэнгис тийш заллаа. Тосгоныхныг нойрноосоо сэрэхэд тэдний сал аль хэдийнэ тэнгэрийн хаяаны цаагуур далд орсон байжээ.

-Хэрэг бүтэж байна... гэж Жеми дуу алдан хашгирав. Банда толгой сэгсэрч,

-Үгүй, одоохондоо бүтсэн юм алга. Энэ чинь дөнгөж эхлэл... гэж хэлээд Бенгалын хүйтэн урсгалд гараа дүрэв. Тэд дарвуулаа дэлгэн умард зүгт хөвлөө. Александрын булан, Шар мөрний адгийн дээгүүр явж өнгөрөхдөө нэгэн сүрлэг нил дэглийнээс өөр амьд амьтны бараа харсангүй. Сал дээр нь лаазалсан мах, хүйтэн тутарга, үр жимс, хоёр дашмаг ус бий боловч сэтгэл нь хөөрөөд юм идэж чадахгүй байлаа. Жеми өмнөөс угтаж буй аюул ослыг бодохгүй гэж өөрийгөө албаджээ. Банда ер тэгж чадахгүй байв. Банда тэнд очиж үзсэн болохоор буу зэвсэг, зуудаг ноходтой харуул манаанıхан, минатай талбайг санаад одоо ийм адал балмад явдалд автсанаа өөрөө гайхаж явлаа. Шотланд залууг хараад “Энэ чинь надаас тэнэг эр юм. Би үхлээ гэхэд муу охин дүүгийнхээ төлөө үхнэ. Энэ хүн юуны төлөө үхэх болж байна” гэж бодлоо. Үд дундын хэрд 5-6 аварга загас үзэгдлээ. Тэр хэдэн аварга загас хурц сэлүүрээрээ ус зүсэн сал руу ойртож ирэв.

-Харав уу? Хар сэлүүртэй юм байна. Энэ чинь хүн иддэг хадарган загас байна хэмээн Банда өгүүлэв. Аварга загаснууд салыг тойрон эргэлдэж байгааг Жеми ажиглаад,

-Одоо бид яадаг билээ? гэсэнд Бандагийн зүрх хөөрөн шүлсээ нэг залгиад,

-Үнэнээ хэлэхэд урьд өмнө нь би ийм юм үзээгүй шүү, Жеми... гэжээ.

Энэ үед нэг аварга загас нуруугаараа салыг шүргэхэд сал золтой л задарч унасангүй. Жеми сэлүүрээ шүүрч аваад аварга загасыг чичсэнд загас сэлүүрийг нь тэр даруй тас хазав. Аварга загаснууд одоо бүр ойртож ирээд яаралгүй тойрон эргэлдэж, аварга том биеэрээ салны захыг шүргэж байлаа. Тийнхүү шүргэн түлхэх тоолонд сал аймшигтай далжийна. Сал хэзээ хэзээгүй задран унаж болох байлаа.

-Биднийг живүүлээгүй байгаа дээр нь эднээс салах хэрэгтэй байна.

-Чи яаж тэгэх юм бэ?

-Надад нэг үхрийн лаазалсан мах аваад аль...

-Тоглож байна уу даа. Ганц лааз мах эдний аманд ч үгүй, хамарт ч үгүй. Чи биднийг л идэх гэнэ... гэж хэлэхтэй зэрэгцэн аварга загас салыг дахин нэг түлхэхэд нь золтой л хөмөрчихсөнгүй.

-Лааз аваад аль, бушуул... гэж Жеми хашгирлаа. Банда хурдан нэг үхрийн лаазалсан мах авч, Жемигийн гарт атгуулав.

-Тагийг нь онгойлго, бушуулаарай... гэхэд Банда халаасныхаа хутга гарган лаазны тагийг хагас онгойлгов. Жеми лаазыг авлаа. Лаазны арзайж барзайсан хурц ирмэгийг хуруугаараа тэмтэрч үзээд,

-Сайн барьж байгаарай... гэж Бандад сануулаад, Жеми салны захад сөхрөн суугаад хүлээж эхэллээ. Бараг тэр даруй амаа ангайж, хурц шүд нь ярзайсан аварга загас үзэгдэв. Жеми загасны нүдийг л харж байлаа. Тэр лаазыг хар чадлаараа атгаж байгаад иржийсэн хурц ирмэгтэй тагаар нь аварга загасны нүдийг цавчив. Аварга загас шарвахад сал нь эгц босоод ирлээ. Орчин тойрных нь ус гэнэт улаанаар будагдав. Бусад аварга загаснууд одоо салыг тоож анхаарахаа болиод шархадсан нөхөр рүүгээ ухасхийв. Аварга загаснууд түүн рүү тал талаас нь дайран тасар татахыг Жеми, Банда хоёр харж байлаа. Сал нь улам улам холдсоор нэг их удалгүй аварга загаснууд харагдахаа болив.

**Үргэлжлэл дараагийн дугаарт...**

